



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛ**

**ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

2024 он

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**

СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БАРИАШИРСҮРЭН, судлаач, хуульч /LLM Hungary/

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ
ТАЙЛАН.**



2024 он

АГУУЛГА

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ	0
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН	0
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО	7
1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал хариуцсан төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;	8
А. Засгийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудал, үйл ажиллагаа эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудад шинээр хүлээлгэсэн үүрэг	8
Б. ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явуулах тухай шинээр үүрэг хүлээлгэсэн зохицуулалтууд	12
1.2.Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;	13
1.2.1. Хөтөлбөр, аргачлал, журам, жишиг үнэ, жагсаалт батлахтай холбоотой үүсэх хүний нөөцийн ачаалал	13
1.2.2. Мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах болон гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой гарах хүний нөөцийг тодорхойлох нь	15
1.2.3. Сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахтай холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь	19
1.2.4. Үндэсний зөвлөл байгуулахтай холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь	20
1.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сан байгуулахтай холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь	Error! Bookmark not defined.
1.2.6. Хувийн туслахаар хангахтай холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь	21
1.2.7. Брайль бичгээр боловсрол эзэмших, мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь	25
1.2.8. Халаалт, түлшний мөнгөн тусламж үзүүлэх насны хязгаарыг 18 болгон нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь	26
1.2.9. Бүрэн хараагүй хүн орон нутгаас нийслэлд ирж шинжилгээ хийлгэхтэй холбогдон гарах зардлыг тодорхойлох нь	Error! Bookmark not defined.
1.2.10. 500 км-ээс дээш зайд алслагдсан нутгаас нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэхтэй холбогдон гарах зардлыг тодорхойлох нь ..	Error! Bookmark not defined.

<i>1.2.11. Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбоотой гарах зардлыг тодорхойлох нь</i>	28
<i>1.2.12. Орон сууцаар хангахтай холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь</i>	32
<i>Хүний нөөцийн нийт хэрэгцээг тодорхойлох нь</i>	37
1.3.Гарах зардлыг урьдчилан тооцох	39
А.Хүний нөөцийн зардал	39
Б.Материаллаг зардал	41
В.Бусад зардал	43
1.4.Зардлыг нэгтгэн тооцож гаргах	44
1.5.Хувилбарыг нягтлах, үр дүнг танилцуулах	45
ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦОХ НЬ	46
2.1.Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох	46
2.2.Зардал тооцох	47
Ажлын хөлсийг тооцох	47
2.3.Тоон үзүүлэлтийг тооцох	50
2.4.Зардлын дүнг тооцож гаргах	52
2.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах	53
2.6. Нэмэлт зардал тооцох	54
2.7.Үр дүнг танилцуулах	55
ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ	57
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	60

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТМС	Техник мэргэжлийн сургууль
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүн
ХБХүүхэд	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХБХХДСан	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сан
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
УИХ	Улсын Их хурал

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Улсын Их хурал /цаашид УИХ гэх/-аас 2016 онд баталж, 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль нь Засгийн газрын /цаашид ЗГ гэх/ 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” баримт бичиг, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, мөн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлого, үйл ажиллагааны баримт бичгүүдэд тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүн /цаашид ХБХ гэх/-д ээлтэй нийгмийн орчны дэд бүтцийг бий болгох, тэдгээрийн эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл, аюулгүй байдлыг хангах тухай зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /цаашид ХНХЯ гэх/ -аас Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд УИХ-аас 2015 онд баталж, 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт зааснаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр нэмэгдсэн зарим зохицуулалт нь өмчийн бүх хэлбэрийн буюу төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд болон энэ хууль хамаарах хүрээнд үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлдэг иргэдэд зардал үүсгэж, үүрэгжүүлсэн зохицуулалт агуулсан бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхэд эрх бүхий байгууллагын дүгнэлтэд үндэслэн олон нийтэд түшиглэн хамруулах үйлчилгээнд хүүхдээ заавал хамруулах үүргийг иргэнд хүлээлгэсэн байна. Иймд хуулийн төслийн зардлын тооцоог төрийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд болон иргэнд үүсэх зардал тус бүрээр тооцож гаргана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэх дараах төрийн болон орон нутгийн байгууллагууд байна. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга,
- Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
- Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага,
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
- Засгийн газар,

- Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,
- Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг шийдвэрлэх эрх, үүрэг бүхий комисс, зөвлөлүүд,
- Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,
- Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
- Хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,
- Эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сан болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих зэрэг сангууд,
- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

Хуулийн төсөл дэх ХБХ-д үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээдэд үүрэг шинээр нэмсэн зохицуулалтуудад хамаарах тооцоог судалгааны 2 дугаар хэсэгт, иргэнл үүсэх ачааллыг 3 дугаар хэсэгт гаргана.

Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд, мөн ХБХ-ий асуудлыг шийдвэрлэх эрх, үүрэг бүхий бусад байгууллага, Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга болон иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- ✓ Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- ✓ Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах; - Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- ✓ Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах зарчмууд багтана.

НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ бүлэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн төрийн байгууллагуудад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагуудад буюу төрд хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолох зорилготой.

Захиргааны байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллагуудад буюу улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолох ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд, төрийн үйлчилгээ үзүүлж буй зөвлөл, комисс, сан зэрэгт хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн байгууллагад буюу уг хуулийн төслийг хэрэгжүүлэх Засгийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сангууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг шийдвэрлэх эрх, үүрэг бүхий комисс, зөвлөлүүдэд үүрэг хүлээлгэж, шинээр нэмэгдсэн зохицуулалтуудаас үүдэн төрд үүсэх ачаалал буюу зардлыг голлох үүрэг гүйцэтгэх төрийн байгууллага тус бүрээр тооцож гаргалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр нэмэгдэж буй хуулийн заалтуудаас харахад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр Засгийн газар болон асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон

төрийн захиргааны байгууллагуудад шинээр 48 зохицуулалтын хүрээнд үүрэг хүлээлгэснийг хүснэгт №1-ээс харж болно.

1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал хариуцсан төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;

Энэ үе шатанд хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон. Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой үйл ажиллагааг хамаарууллаа.

Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг гүйцэтгэх хугацааг үндэслэн тооцлоо. Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзэв. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана. 1 жил = ажлын 200¹ өдөр 1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/ 1 цаг = ажлын 60 минут Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96000 минут ажиллана гэж үзсэн.

А. Засгийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудал, үйл ажиллагаа эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудад шинээр хүлээлгэсэн үүрэг

Хуулийн төсөлд Засгийн газар, ХБХ-ий эрхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон боловсрол, эрүүл мэнд, хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагууд, сангуудад үүрэг хүлээлгэх замаар зардал үүсгэх дараах зохицуулалтыг агуулсан байна.

№	Хуулийн төсөл дэх шинээр үүрэг хүлээлгэсэн зохицуулалт	
1.	Засгийн газарт хүлээлгэсэн үүрэг	18.3.Энэ хуулийн 32.2.4-т заасан комиссын дүрэм, Эрүүл мэндийн даатгалын сангаас хиймэл эрхтэн, туслах хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ, түүнд тавигдах шаардлага, олгох журмыг Засгийн газар батална.
2.		21.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах орон сууц, орон байрны хөтөлбөрийг Засгийн газар батална.
3.		37.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллуулж болно.
4.		22.2.Энэ хуулийн 22.1-д заасан хөнгөлөлт, тусламжийн жагсаалт, жишиг үнэ, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална. 22.4.Энэ хуулийн 22.3-т заасан харилцааг зохицуулах журмыг Засгийн газар баталж, шаардагдах хөрөнгийг нийтийн тээврийн

¹ хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

		үйлчилгээ үзүүлсэн аймаг, Нийслэлийн жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.
5.		35.1.2.Төсвийн ерөнхийлөн захирагчдын жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;
6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд шинээр хүлээлгэсэн үүрэг	7.2.энэ хуулийн 7.1.1-т заасан сургалтыг зохион байгуулах, төлбөрийн хэмжээг зохицуулсан журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална
7.		20.3.Энэ хуулийн 19.1-д заасан үйлчилгээний удирдамжийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.
8.		21.3.2.гэр хороололд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдарч байгаа орон байрыг инженерийн дэд бүтэц болон тохируулгаар хангах зорилгоор нэг удаагийн дэмжлэг үзүүлэх;
9.		24.5.Энэ хуулийн 24.3-т заасан үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална
10.		28.1.18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхтэй.
11.		28.7.Энэ хуулийн 28.2.6-д заасан үйлчилгээний журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, хөдөө аж ахуйн, хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
12.		28.3.Энэ хуулийн 28.2.1-28.2.5-д заасан үйлчилгээний журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
13.		28.4.Энэ хуулийн 28.2.1-28.2.5-д заасан үйлчилгээний жишиг зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална
14.		32.5.Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, эрүүл мэндийн, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална
15.		37.7.7.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дээдлэгч байгууллага, иргэнийг шалгаруулан алдаршуулах журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хэрэгжүүлэх
16.	42.2.Энэ хуулийн 42.1-т заасан нийгмийн баталгааны хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, шаардлагатай хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн жилийн төсөвт тусгана	
17.	Боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд шинээр хүлээлгэсэн үүрэг	9.2.Боловсролын ерөнхий хуулийн 11.6-д заасан үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах идэвх, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, түүний онцлог хэрэгцээнд нийцүүлэн брайль үсэг, монгол дохионы хэл болон бичгийн монгол хэлний хосолсон арга зүй, харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох, зөвлөн туслахад чиглэсэн дэмжих үйлчилгээг хамруулах ба дэмжих үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмыг боловсролын, эрүүл мэндийн,

		хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална
18.		10.2.Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сангаас санхүүжүүлнэ.
19.		10.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох үйл ажиллагааг дагнан явуулж байгаа сургалтын байгууллагын үйл ажиллагааны зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ба жишиг зардлыг тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
20.		11.4.Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулагч бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сонгогч, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн эрх, ашгийг хамгаалдаг болон тэдэнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
21.		11.5.Дохионы хэлмэрч, орчуулагч бэлтгэх ажлыг сонгогч, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн эрх, ашгийг хамгаалдаг болон тэдэнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.
22.		24.5.Энэ хуулийн 24.3-т заасан үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
23.		17.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг хүний нөөцийн судалгааг гаргаж боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэх
24.		32.5.Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, эрүүл мэндийн, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална
25.	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн	21.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууц, хүртээмжтэй орон байраар хангах чиглэлээр барилга, хот байгуулалтын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.;
26.		21.3.2.гэр хороололд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдарч байгаа орон байрыг инженерийн дэд бүтэц болон тохируулгаар хангах зорилгоор нэг удаагийн дэмжлэг үзүүлэх
27.	Аймаг, нийслэлийн Засаг дарга	21.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууц, хүртээмжтэй орон байраар хангах чиглэлээр барилга, хот байгуулалтын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
28.		11.4.Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулагч бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сонгогч, хэл ярианы

		бэрхшээлтэй иргэдийн эрх, ашгийг хамгаалдаг болон тэдэнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
29.	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн захиргааны төв байгууллага	13.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 жил тутамд батална.
30.		37.5.Үндэсний хорооны ажлын албаны үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, салбар хорооны ажлын албаны үүргийг тухайн орон нутгийн нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн нэгж тус тус гүйцэтгэнэ.
31.		42.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний салбарын ажилтанд ажилласан 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх 1 удаагийн мөнгөн урамшуулал олгох;
32.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	36.1.8.хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;
33.		37.5.Үндэсний хорооны ажлын албаны үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, салбар хорооны ажлын албаны үүргийг тухайн орон нутгийн нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн нэгж тус тус гүйцэтгэнэ.
34.	Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	24.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн стандартыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.
35.		22.1.5.нийслэлээс 500 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, нарийн мэргэжлийн шинжилгээ хийлгэх тохиолдолд хот хоорондын зорчигч тээврийн жишиг үнийг үндэслэн тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүнд унааны зардлыг жилд нэг удаа 100 хувь, хууль ёсны асран хамгаалагчид 50 хувийг нөхөн олгох;
36.		28.5.Энэ хуулийн 28.2.1-28.2.4-т заасан үйлчилгээний зардлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.
37.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	27.4. Энэ хуулийн 27.2.1-т заасан хувийн туслах үйлчилгээ үзүүлэх ажилтныг бэлтгэх сургалтын зардал болон хувийн туслахын цалин хөлсийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ .

Дээрх зохицуулалтаас харахад ЗГ болон ЗГ-ын гишүүн, төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэсэн үүрэг нь гол төлөв ХБХ-ийн эрхийг хангах чиглэлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэгдсэн журам, аргачлал, жишиг үнэ, жагсаалт, хөтөлбөр зэрэг баримт бичиг боловсруулах, батлах, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулах зэрэг үйл ажиллагааг тусгасан байна. Хуулийн төсөлд тусгагдсан, шинээр үүрэг хүлээлгэсэн энэ төрлийн зохицуулалтыг хариуцах байгууллага тус бүрээр авч үзвэл

1. **Засгийн газарт:** хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь, 22 дугаар зүйлийн 22.2, 22.4, 17.12 дахь, 35 дугаар зүйлийн 35.1.2, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, заалтууд,
2. **ХБХ-ий асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд:** хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 20 дугаар зүйлийн 20.3, 21 дүгээр зүйлийн 21.3.2, 24 дүгээр зүйлийн 24.5, 28 дугаар зүйлийн 28.1, 28.3, 28.4, 28.7 дахь, 37 дугаар зүйлийн 37.7 дахь, 42 дугаар зүйлийн 42.2 дахь, хэсэг, заалтууд,
3. **Боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд:** хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь, 10 дугаар зүйлийн 10.2 дахь, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь, 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг, заалтууд,
4. **Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд:** 24 дүгээр зүйлийн 24.5 дахь, 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг,
5. **Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад:** 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу журам, стандарт, жишиг зардлын хэмжээ, жагсаалт, сургалтын хөтөлбөр, удирдамж, шаардлага батлах үүрэг хүлээлгэсэн байна.

Б. ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явуулах тухай шинээр үүрэг хүлээлгэсэн зохицуулалтууд

Өмнөх хэсэгт тодорхойлсон буюу Засгийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудал, үйл ажиллагаа эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудад шинээр хүлээлгэсэн /Хүснэгт 1/ нь зохицуулалтууд нь ХБХ-ий хөгжлийг дэмжих зорилгоор эрүүл мэнд, боловсрол, спортын зэрэг салбарын үйл ажиллагаанд оролцох орчин нөхцөл, боломжийг сайжруулах, ХБХ-ий нийгмийн халамжийн асуудлыг шийдвэрлэхээс гадна тэдний хөдөлмөр, хичээл зүтгэлийг үнэлэх, урамшуулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тусгасан байна. Иймээс хуулийн төсөлд шинээр тусгагдсан “хувийн туслах” үйлчилгээ авах эрхийг хэрэгжүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний оршин суугаа орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах зорилгоор нэг удаагийн дэмжлэг үзүүлэх, орон сууцаар хангах, Магистр, докторын зэрэг хамгаалахаар суралцаж буй 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн төлбөрийг төрөөс нэг удаа 100 хувь хариуцахтай холбогдон гарах зардлаас гадна ХБХүүхдийн насны хязгаарыг 18 болгож өөрчилсөн, ХБХ шинжилгээ хийлгэх, сувилалд сувилуулахтай холбогдон гарах зардлыг урьдчилсан байдлаар тоймлон гаргана.

Түүнчлэн ХБХ-ийг нийгмийн харилцаа, үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй оролцох нөхцөлийг хангах зорилгоор брайль үсэг, текст уншигч зэрэг туслах хэрэглэгдэхүүнтэй байх хуулийн шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн байгууллагуудад гарах зардал, мөн дээрх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, бодлого, арга зүй, санхүүжилтээр хангах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл байгуулах, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг хүний нөөцийн судалгаа гаргахтай холбогдон гарах зардлыг мөн тоймлон гаргана.

1.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;

1.2.1. Хөтөлбөр, аргачлал, журам, жишиг үнэ, жагсаалт батлахтай холбоотой үүсэх хүний нөөцийн ачаалал

Хуулийн төсөлд шинээр нэмэгдсэн зохицуулалтуудаар хөтөлбөр, аргачлал, журам, жишиг үнэ, жагсаалт батлах замаар хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах Засгийн газар, ЗГ-ын гишүүд, ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулах төрийн захиргааны төв байгууллагуудад үүрэг хүлээлгэсэн байна. Эдгээр хөтөлбөр, аргачлал, журам, жишиг үнэ, жагсаалт батлахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах давтамж тогтмол биш эсхүл жилдээ 1 гүйцэтгэх тул аргачлалын дагуу давтамжийг 1 гэж тооцлоо.

Хүлээсэн үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөц
Засгийн газарт: хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь, 22 дугаар зүйлийн 22.2, 22.4, 17.12 дахь, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, заалтууд, ХБХ-ий асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд: хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 20 дугаар зүйлийн 20.3, 21 дүгээр зүйлийн 21.3.2, 24 дүгээр зүйлийн 24.5, 28 дугаар зүйлийн 28.1, 28.3, 28.4, 28.7 дахь, 37 дугаар зүйлийн 37.7 дахь, 42 дугаар зүйлийн 42.2 дахь, хэсэг, заалтууд, Боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд: хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь, 10 дугаар зүйлийн 10.2 дахь, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь, 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг, заалтууд, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд: 24 дүгээр зүйлийн 24.5 дахь, 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад: 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу	ХБХ-ийн эрхийг хангах чиглэлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэгдсэн журам, аргачлал, жишиг үнэ, жагсаалт, хөтөлбөр зэрэг баримт бичиг боловсруулах, батлах	мэдээлэл цуглуулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		Цуглуулсан мэдээллийг нэгтгэн судалж, үнэлэх	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
		Баримт бичгийн төсөл болон танилцуулга боловсруулах	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
		Баримт бичгийн төслийг холбогдох газар нэгжүүдэд хүргүүлж, санал авах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн төслийг эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
		Баримт бичгийн төсөлтэй танилцаж, шаардлагатай мэдээлэл цуглуулах, бусад холбогдох байгууллагаас санал авч нэгтгэх	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		Баримт бичгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан батлах	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480

журам, стандарт, жишиг зардлын хэмжээ, жагсаалт, сургалтын хөтөлбөр, удирдамж, шаардлага батлах үүрэг хүлээлгэсэн байна.					
Нийт			5760		

Дээрх хүснэгтэд ХБХ-ийн эрхийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай **хөтөлбөр, аргачлал, журам, жишиг үнэ, жагсаалт боловсруулах, батлахтай** холбоотой 1 үйл ажиллагаанд зарцуулах дундаж хугацааг тооцов. Энэхүү тооцооллоор хуулийн төсөлд тусгасан журам, стандарт, жишиг зардлын хэмжээ, жагсаалт, сургалтын хөтөлбөр, удирдамж, шаардлага батлах үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Нэг жилд шаардагдах ажлын цаг/минут	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Засгийн газар /ЗГ-ын гишүүн/ ²	$5,760 \times 41 = 236,285$ минут/3,938 цаг	96,000	2,46
Боловсролын асуудал эрхэлсэн ТЗТБ	$5760 \times 2 = 11,520$ минут/192 цаг	96000	0,12
Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	$5760 \times 1 = 5760$ минут/96 цаг	96000	0,06
Нийт		2,64	

Дээрх тооцооллоос харахад ХБХ-ий эрхийг хангах үйл ажиллагаанд хамаарах хөтөлбөр, аргачлал, журам, жишиг үнэ, жагсаалт боловсруулах, батлахтай холбоотой үүргийг хэрэгжүүлэхэд Засгийн газар болон Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудад нийт 3,06 хүний нөөцийн хэрэгцээ үүснэ. Үүнийг үүрэг хүлээсэн этгээд тус бүрээр авч үзвэл:

1. Засгийн газарт 21 журам, жишиг үнэ, жагсаалт зэргийг батлах ажлын хүрээнд 120,960 минут буюу 2,016 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд **1,26** хүн шаардагдана.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд 63,360 минут буюу 1,056 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд **0,66** хүн шаардагдана.
3. Боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд 34,560 минут буюу 576 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд **0,36** хүн шаардагдана.
4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд 17,280 минут буюу 288 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд **0,18** хүн шаардагдана.
5. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 11,520 минут буюу 192 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд **0,12** хүн шаардагдана.

² ЗГ батлах 21, 1 сайд батлах 5, 2 сайд хамтран батлах 4, 3 сайд хамтран батлах 4, нийт 34 журмыг 46 ажлын хэсэг/мэргэжилтэн боловсруулна.

6. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 5,760 минут буюу 96 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд **0,06** хүн шаардагдана.

Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр тусгагдсан хөтөлбөр, аргачлал, журам, жишиг үнэ, жагсаалт боловсруулах, батлахтай холбоотой үүргийг хэрэгжүүлэхэд ЗГ болон дээр дурдсан ЗГ-ын гишүүд буюу төрийн захиргааны төв байгууллагууд дотоод зохион байгуулалт, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар хүний нөөцийн ачаалал шинээр үүсгэхгүй байх боломжтой байна.

1.2.2. Мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах болон гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой гарах хүний нөөцийг тодорхойлох нь

Хуулийн төсөлд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцаа тусгагдсанаар төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь, 15 дугаар зүйлийн 15.3 дахь, 17 дугаар зүйлийн 17.3 дахь, 24 дүгээр зүйлийн 24.9 дэх, 25 дугаар 25.1.4 дэх хэсэг, заалтад ХБХ-нд харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох, бэлгийн болон нөхөн үржихүй, дэмжих үйлчилгээ, биеийн тамир спортыг дэмжих, хүүхдээ өсгөх, хүчирхийллээс хамгаалах, сэтгэлзүйн туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг холбогдох төрийн байгууллага, сангаас гаргах зохицуулалт оржээ.

Энэ хэсэгт дээр дурдсан шинээр нэмэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны байгууллагад юуны өмнө тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлага хангасан байгууллагыг **сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой зардал** болон эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах **тайлан мэдээ бэлтгэх, танилцуулах** зэрэг стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал буюу хүний нөөцийг тоймлон тодорхойлно.

Төрийн байгууллагаас хийгдэх тайлан, мэдээ хүргүүлэх, мэдээллийг шалгах, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагааны давтамж болон тохиолдлын тоог хуулийн төсөл дэх зохицуулалтаас тодорхойлох боломжгүй байгаа тул давтамжийн тоог жилд 1 удаа байхаар тооцож, тохиолдлын тоог ХБХ-ий эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дээр дурдсан 5 зүйл, хэсэгт заасан 5 чиглэлээр нэг нэг байгууллагатай, ХБХүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр 7 ТББ-тай³ гэрээ байгуулан ажиллана гэж үзэн зардлын тооцооны тохиолдлын тоог дундажлан тооцож хүний нөөцийн хэрэгцээг гаргалаа.

Харин сонгогдсон мэргэжлийн болон төрийн бус байгууллага тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой гарах зардлыг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлийн төрөл, түвшнөөс хамааран зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зардал харилцан адилгүй байх тул энд тооцоолох боломжгүй гэж үзлээ.

ХБХ-ийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр нэмэгдсэн зохицуулалтуудаар хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах эрх бүхий субъектүүдийн **сонгон**

³ Боловсрол, шинжлэх ухааны сайдын байнгын хорооны хуралд танилцуулсан мэдээлэлд суурилав.

шалгаруулалт зохион байгуулах, тайлагнах, мэдээлэл хүргүүлэх, мэдээллийг шалгах, үнэлэлт дүгнэлт өгөх үйл ажиллагааг боловсролын асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал, эрүүл мэндийн асуудал, биеийн тамир спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хамаарна. Иймд эдгээр үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлохын тулд жишиг бодолт хийлээ. Ингэхдээ нэг ажилд зарцуулах стандарт үйл ажиллагаа, түүнд зарцуулах ажлын цагийг гаргаж, тухайн үйл ажиллагааг нэг жилд дунджаар 1 удаа гүйцэтгэнэ гэж үзэн давтамжийн тоог 1 гэж тооцон хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Хүлээсэн үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа/мин	Дав-тамж	Хүний нөөц
Хуулийн төсөл дэх төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх үйл ажиллагаатай холбоотой 7.3, 15.3, 17.3, 24.9, 25.1.4 дэх заалтын хүрээнд	хамтран ажиллах мэргэжлийн байгууллага болон гэрээлэн гүйцэтгүүлэх төрийн бус байгууллага сонгон шалгаруулах үйл ажиллагаа	Бичиг баримт хүлээн авах	10	1	10
		Баримт бичгийг нягтлах	30	1	30
		Сонгон шалгаруулалтад оролцож буй баримт бичгийг холбогдох газар нэгжүүдийн санал судлах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Холбогдох газар нэгжүүдээс ирүүлсэн санал, зөвлөмжийг үнэлэх	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
		Сонгон шалгаруулалтын үр дүн гаргах	180	1	180
		Зөвшөөрсөн эсхүл татгалзсан тухай албан бичиг боловсруулах	30	1	30
		Бүртгэл хөтлөх	15	1	15
		Сонгон шалгаруулалтад байгууллагад мэдэгдэл хүргүүлэх	20	1	20
		Гэрээ байгуулах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Олон нийтэд хүргэх мэдээлэл бэлтгэх	60	1	60
		Сонгогдсон байгууллагын талаар олон нийтэд мэдээлэл түгээх	60	1	60
Нийт			2805		

Дээрх хүснэгтэд ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага болон гэрээлэн гүйцэтгэх төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахтай холбоотой үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах нийт ажлын цагийг жишиг байдлаар 2805 минут байна гэж тооцов.

Нэгж	Үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
ХБХ-ий асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага	24.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.	2805	7	1	7	0,2
	24.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдээ өсгөн бойжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгох ажлыг төрийн буса байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.	2805	1	1	1	0,029
	25.1.3.Энэ хуулийн 25.1.1 /гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон /-т заасан үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.	2805	1	1	1	0,029
Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	17.3. Энэ хуулийн 17.1.3-т заасан үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалар төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.	2805	1	1	1	0,029
нийт					0,29	

Дээрх тооцооллоос харахад төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дээр дурдсан 2 байгууллагад 0,29 хүний нөөцийн хэрэгцээ үүсэх ба үүнээс

- ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад **0,25** хүн,
- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад **0,029** хүн шаардлагатайг харуулж байна.

Харин сонгон шалгаруулалтын шаардлага хангаж тодорхой үйл ажиллагааг гэрээлэн гүйцэтгэж буй төрийн бус байгууллагууд болон мэргэжлийн байгууллагын гүйцэтгэж буй үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээ, мэдээлэл бэлтгэх, хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөхөд төрийн байгууллагын зүгээс стандарт үйл ажиллагааг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлохдоо гэрээ байгуулсан байгууллага тус бүр дээр нэг жилд дунджаар 1 удаа гүйцэтгэнэ гэж үзэн давтамжийн тоог 1, тохиолдлын тоог 5+7 гэж тооцон хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Хүлээсэн үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөц
Хуулийн төсөл дэх төрийн зарим чиг үүргийг төрийн	Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах болон	Мэдээлэл цуглуулах	1440 мин	1	1440
		Цуглуулсан мэдээлэл, өгөгдөхүүнийг нэгтгэн судалж, үнэлэх	480 мин	1	480

бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх үйл ажиллагаатай холбоотой 7.3, 15.3, 17.3, 24.9, 25.1.4 дэх заалтын хүрээнд	төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхтэй холбоотой тайлан, мэдээ хүргүүлэх үйл ажиллагаа	Тайлан, мэдээний төслийг боловсруулах/үнэлэх/хянах	480 мин	1	480
		Тайлан, мэдээний төслийг холбогдох газар нэгжүүдэд хүргүүлж, санал авах	960 мин	1	960
		Холбогдох газар нэгжүүдээс ирүүлсэн санал, зөвлөмжийг нэмж тусгах, засвар оруулах	480 мин	1	480
		Төслийг эцэслэн боловсруулж эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх	960 мин	1	960
Нийт			4800		

Дээрх хүснэгтэд ХБХ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр тодорхой үйл ажиллагааг гэрээлэн гүйцэтгэх төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээ хүргүүлэх, мэдээллийг шалгах, үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах нийт ажлын цагийг жишиг байдлаар 4800 минут байхаар тооцов.

Нэгж	Үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Давгамж	Тоон үзүүлэлт	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
ХБХ-ий асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага	24.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.	4800	1	1	7	0,35
	24.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдээ өсгөн бойжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгох ажлыг төрийн буса байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.	4800	1	1	1	0,05
	25.1.3.Энэ хуулийн 25.1.1 / гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон /-т заасан үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.	4800	1	1	1	0,05
Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	17.3. Энэ хуулийн 17.1.3-т заасан үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалар төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.	4800	1	1	1	0,05
Нийт		0,5				

Дээрх тооцооллоос харахад төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх дэмжих үйлчилгээний чиглэлээр 7, бусад үйл ажиллагаатай холбоотой нэг төрийн бус байгууллагын тайлан, мэдээ хүргүүлэх, мэдээллийг шалгах, үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэхэд нийт 0,94 хүний нөөцийн хэрэгцээ үүсэхээс

- ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад **0,45** хүн,

- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад **0,05** хүн шаардлагатайг харуулж байна.

Дээрх тооцооллоос харахад хуулийн төсөлд шинээр тусгасан төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой сонгон шалгаруулах, тайлан мэдээ авах, нэгтгэх үйл ажиллагаатай холбогдуулан тооцоолол хийгдсэн 2 байгууллагын хэмжээнд нийт

- ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад **0,7** хүн,
- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад **0,079** хүн шаардлагатайг харуулж байна.

1.2.3. Сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахтай холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь

Хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь хэсэгт ХБХ-ий асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад “... хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт, **сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг** зохион байгуулах” үйл ажиллагааг шинээр нэмж тусгажээ. Иймд энэхүү үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлохын тулд жижиг бодолт хийлээ. Ингэхдээ нэг ажилд зарцуулах стандарт үйл ажиллагаа, түүнд зарцуулах ажлын цагийг гаргаж, тухайн үйл ажиллагааны давтамжийн тоог улиралд 1 удаа зохион байгуулахаар буюу 4 гэж, харин тохиолдлын тоог 1 төрлийн сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр дундажлан тооцон хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Хүлээсэн үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Дав-тамж	Хүний нөөц
Хуулийн төслийн төрийн захиргааны байгууллагад хамаарах 36.1.8 дахь хэсэг	хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Нөлөөллийн арга хэмжээ/ Сурталчилгааны агуулгыг тодорхойлох	1 өдөр /8цаг/ 480 мин	4	1920
		Шаардлагатай мэдээлэл цуглуулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	4	5760
		Нөлөөллийн ажил/ сурталчилгааны материал боловсруулах	1 өдөр /8цаг/ 480 мин	4	1920
		Санал авах	1 өдөр /8цаг/ 480 мин	4	1920
		санал, зөвлөмжийг нэмж тусгах, засвар оруулах	1 өдөр /8цаг/ 480 мин	4	1920
		Хэвлэх, олшруулах,	0,5 өдөр /4цаг/ 240 мин	4	960
		Нөлөөллийн ажил/сурталчилгаа зохион байгуулах	1 өдөр /8цаг/ 480 мин	4	1920
		Нөлөөллийн ажил/сурталчилгааны үр дүнгийн талаар тайлан гаргах	0,5 өдөр /4цаг/ 240 мин	4	960
Нийт			17280		

ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь хэсэгт шинээр хүлээлгэсэн сурталчилгаа, нөлөөллийн ажил

зохион байгуулах үүргийг нэг жилд 4 удаа буюу улиралд нэг удаа хэрэгжүүлэхээр тооцож үзлээ.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ/минут	Нэг жилд шаардагдах ажлын цаг/минут	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Төрийн захиргааны байгууллага	17280 минут	96000	0,18

Үүнээс харахад төрийн захиргааны байгууллага сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах үүргийг хэрэгжүүлэхэд 17280 минут буюу 288 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд **0,18** хүн шаардагдана.

1.2.4. Үндэсний хороо байгуулахтай холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь

Хуулийн төслийн 37 дугаар зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын бодлого, үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд, дэд зөвлөлүүдийг төрийн захиргааны төв байгууллагуудад, салбар зөвлөлүүдийг аймаг, нийслэл, дүүрэгт байгуулна гэж заажээ. Харин Үндэсний Зөвлөлийн ажлын албаны үүргийг ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбар зөвлөлийн ажлын албаны үүргийг орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэхээр тусгасан байна.

Хуулийн төсөлд тусгасан Үндэсний зөвлөл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулан байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл”-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх юм. Энэхүү орон тооны бус зөвлөл нь төрийн захиргааны төв байгууллага болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд орон тооны бус дэд зөвлөл, аймаг, нийслэл, дүүрэгт орон тооны бус салбар зөвлөлтэй⁴ ажиллаж байгаа бөгөөд Зөвлөлийн ажлын албаны үүргийг ХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн асуудал хариуцсан нэгж хариуцан ажиллаж байна.⁵

Иймээс хуулийн төслийн 37 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөлийг одоо ажиллаж байгаа тогтолцоонд түшиглэн байгуулах боломжтой тул дэд болон салбар зөвлөл шинээр байгуулан ажиллуулах зардал үүсэхгүй гэж үзлээ.

Харин зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааг хариуцаж буй ХНХЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн асуудал хариуцсан нэгжид орон тооны бус Зөвлөлийг байнгын ажиллагаатай Үндэсний зөвлөл болгож буйтай холбоотой хүний нөөцийн хэрэгцээ шинээр бий болох магадлалтай байна. Иймээс ажлын албаны хүний нөөцийн хэрэгцээг энд тооцож үзье.

⁴ ЗГ-ын 2016 оны 136 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам. 4.1.

⁵ дээрх журмын 6.1.

Ингэхдээ Ажлын алба нь 16 яам⁶, Харилцаа холбооны зохицуулах газрыг дэргэдэх дэд зөвлөлүүд болон 21 аймаг, нийслэл болон 9 дүүргийн салбар зөвлөлөөс ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, жилд 2-оос доошгүй удаа хуралдаан зохион байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах ажлын цаг, улмаар хүний нөөцийг тоймлон тодорхойлохыг зорьно.

Үндэсний Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагаан хэрэгжүүлэхээс гадна тайлан, мэдээлэл хүргүүлэх, мэдээллийг шалгах, үнэлэлт дүгнэлт өгөх үйл ажиллагааг 1 дэд/салбар зөвлөлийн тухайд өмнө тооцсон 4800 минутаар тооцов. Мөн дээрх ажлыг 1 жилд 2 удаа /хагас, бүтэн жилээр/ гүйцэтгэхээр тохиолдлын тоог тогтоов.

Нэгж	Үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Төрийн захиргааны байгууллага	Байнгын ажиллагаатай Үндэсний Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх	4800	47 ⁷	2	94	4,7

Үүнээс харахад хуулийн төслийн 37 дугаар зүйлд зааснаар төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд 451,200 минут буюу 7520 цагийн ажлын ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд **4,7 хүн** шаардлагатайг харуулж байна.

1.2.5. Хувийн туслахаар хангахтай холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь

Дэмжих үйлчилгээний журмыг хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хувийн туслах бэлтгэх, сургах зардал, цалин хөлсийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх⁸ бөгөөд энэ хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1 дэх заалтад заасан хувийн туслахын үйлчилгээг хүүхэдтэй ХБ-тэй эцэг, эх, асран хамгаалагч⁹, 18-аас дээш насны ХБХ¹⁰, 0-2 насны хүүхэдтэй байнгын асаргаа шаардлагатай ХБ-тэй эх аьч боломжтой бөгөөд цаг үеийн нөхцөл байдлаас үл хамааран тасралтгүй авах эрхтэй¹¹ байхаар тусгажээ.

⁶ [https://mn.wikipedia.org/wiki/ Монгол_Улсын_Засгийн_Газар](https://mn.wikipedia.org/wiki/Монгол_Улсын_Засгийн_Газар)

⁷ 16 яам, харилцаа холбооны газар, 21 аймаг, нийслэл, 9 дүүргээр тооцов.

⁸ Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 28.2.1-28.2.4-т заасан үйлчилгээний зардлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

⁹ хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтад “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч нь хүүхдийг энэ хуулийн 32.8-д заасан дүгнэлтийн дагуу хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээнд хамруулна.

¹⁰Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт 18 настай ХБХ-ий бие даан амьдрах эрх нь дараах дэмжих үйлчилгээгээр хангана: 28.2.1. Хувийн туслахын үйлчилгээгээр хангагдана.”

¹¹ Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь хэсэгт “энэ хуулийн 27.2.1 -т заасан дэмжих үйлчилгээг байгалийн гамшиг, цар тахлын үеийн хөл хорио, нийтийг хамарсан үймээн самуун, бослого тэмцэл, ажил хаялт,

Үүнээс харахад хувийн туслахын үйлчилгээг 18-аас дээш насны ХБХ эдлэх боломжтой байна.

Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцохын тулд тодорхой тоо баримтыг судлах шаардлагатай бөгөөд манай улсын хувьд ХБХ-тэй холбоотой мэдээлэл төдийлөн хангалттай, тодорхой биш, нэгдсэн тоо мэдээлэл гаргахад хүндрэлтэй байна. Үүний нэг жишээ бол ХБ хүүхдийн статистик мэдээг 15, 18 зэргээр насны зөрүүтэй гаргадаг, ХБХ-ийн судалгааг бэрхшээлийн төрлөөр гаргадаг боловч насны ангилал байдаггүй зэргээс шалтгаалан тухайлбал нөхөн үржихүйн насны ХБ эмэгтэйчүүдийн мэдээлэл байхгүй зэрэг жишээ дурдаж болох юм.

Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээллээс харахад Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 115,115 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагаас¹² ойролцоогоор 45,922 нь эмэгтэй¹³ байна. Харин 0-18 насны 11385 ХБ хүүхэд байгаагаас боловсролын насны 8228 хүүхэд¹⁴ байна. Боловсрол эзэмших насны ХБ хүүхдүүдийн 64% нь, тодруулбал СӨБ-ын насны 1930 хүүхдээс 1498, ЕБС-ийн насны 9500 хүүхдээс 5653 хүүхэд ямар нэг сургалтын байгууллагад хамрагдаж байгаа бол үлдсэн СӨБ-ын насны 430, ЕБС-ийн насны 3817 хүүхэд сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байна. Түүнчлэн МСҮТ-л 643, их, дээд сургуульд 414 ХБ оюутан суралцаж байна.

Дээрх тоо мэдээллийг ашиглан хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтад заасан хүүхэдтэй ХБ-тэй эцэг, эх, асран хамгаалагчийн тоог тогтоохыг оролдсон бөгөөд ингэхдээ ХБХ-ий нийт тооноос 15 хүртэлх насны 9,865 хүүхэд болон нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон 40406 өндөр настны тоог, мөн 0-2 насны хүүхдээ асарч буй байнгын асаргаанд байдаг эхийн тоог хасаж **51,258** ХБХ хувийн туслахын үйлчилгээ авах магадлалтай гэж тооцов.

Мөн 0-2 настай хүүхдээ асарч буй байнгын асаргаа шаардлагатай эхийн тоог гаргахдаа 2021 оны байдлаар байнгын асаргаанд байгаа 30946 ХБХ-ий тоо¹⁵, ХБХ-ий дунд эзлэх эмэгтэйчүүдийн хувь /43,1%/¹⁶, мөн нөхөн үржихүйн нас буюу 15-46 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь /27,2%/¹⁷ хэмжээнд тулгуурлан байнгын асаргаа шаардлагатай ХБ эмэгтэйчүүдийн тоог 17091 гэж, үүнээс нөхөн үржихүйн насны **4,648** эмэгтэй байхаар тооцоолов.

Хуулийн төслийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт 18 настай ХБХ хувийн туслах үйлчилгээ авах эрхтэй гэж заасныг 18 наснаас эхлэн хувийн туслахын үйлчилгээ авах

бүх нийтийн амралт, баяр ёслолын өдрүүдээс үл хамааран бүх цаг үе, нөхцөл байдалд тасалдуулахгүй авах боломжоор хангах”

¹² Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар. 2022 оны статистик мэдээ.

<http://www.gadpwd.gov.mn/index.php/page/591>

¹³ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар. 2021 оны статистик мэдээ. Эх сурвалж:

<http://www.gadpwd.gov.mn/images/tts/1f8a3-statistic-2022-converted.pdf>

¹⁴ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын өнөөгийн байдал. БШУ-ны сайд Л.Энх-Амгалангийн УИХ-ын байнгын хороодын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хийсэн танилцуулгаас.

¹⁵ <http://www.gadpwd.gov.mn/images/tts/1f8a3-statistic-2022-converted.pdf>

¹⁶ ХЭҮК-оос 2019 онд хийсэн судалгаанд ашигласан тоон мэдээлэл. Эх сурвалж: <https://nhrcm.gov.mn/> хөгжлийн-бэрхшээлтэй-охид-эмэгтэйчүүдийн-бэлгийн-болон-нөхөн-үржихүйн-эрүүл-мэндийн-эрхийн-судалгаа/

¹⁷ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН нөхөн үржихүйн эрүүл мэнд. ҮСХ. 2018 он. Эх сурвалж:

https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Abortion_last.pdf&ln=Mn

эрхтэй гэж тайлбарлан 18-аас дээш насны ХБХ-ий тоог гаргахыг зорив. ҮСХ-оос гаргаж буй статистик 15 насаар заагласан нь тоон мэдээлэл гаргахад хүндрэл учруулсан. Иймээс 2010 онд ҮСХ-оос Хүн ам, орон сууцны улсын тооллогын дүнд суурилан боловсруулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд” сэдэвчилсэн судалгааны тайлан¹⁸ дахь мэдээлэлд үндэслэн ХБХ-ий дунд 0-19 нас хүртэлх насны иргэдийн эзлэх хувь 13% байна гэж тооцоолон уг үзүүлэлтийг 2022 онд бүртгэгдсэн ХБХ-ий тоотой харьцуулан 20-оос дээш насны ХБХ-ий тоог ойролцоогоор 100,150 ХБХ байна гэж үзлээ. Үүнээс хувийн туслахын үйлчилгээг давхардуулж олгохгүй гэх зарчмын хүрээнд өмнөх хэсэгт гаргасан тоон үзүүлэлтийг хасаж тооцсоноор **44,244** ХБХ уг үйлчилгээг авна гэж тооцлоо.

Хэдийгээр дээрх зохицуулалтуудаар хүүхэдтэй ХБХ-д хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх асуудлыг илүүд үзэж байгаа мэт боловч хуулийн төслийн 27.1 дэх хэсэгт заасан 18-тай ХБХ бие даан амьдрах эрхтэй бөгөөд үүнийг хувийн туслахын үйлчилгээгээр дэмжинэ гэх зохицуулалтаар насанд хүрсэн ХБХ-ийг нэлэнхүйд нь буюу ойролцоогоор **95,502** ХБХ-ийг хамруулна гэж харж болохоор байна.

Иймээс дээрх тоон үзүүлэлтийг хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх тохиолдлын тоо болгон ашиглана. Хувийн туслахтай холбоотой зардлыг хуулийн төслийн 27.4 дэх хэсэгт заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн сангаас гаргах бөгөөд энэ үйл ажиллагаатай холбоотой өргөдлийг улсын хэмжээнд Хөдөлмөр халамжийн газар хүлээн авч шийдвэрлэнэ гэж үзлээ.

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиролдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ/ минут
Хувийн туслах үйлчилгээ авагчийг бүртгэх, мэдээллийн санд оруулах	Материал хүлээж авах	2	95,502	191,004
	Мэдээллийг хянах, шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хянах	10	95,502	955,020
	Бүртгэх эсэх талаар шийдвэр гаргах	30	95,502	2,865,060
	Бүртгэлийн баримт олгох	3	95,502	286,506
	Бүртгэлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх	60	95,502	5,730,120
	Хуулбарлах	3	95,502	286,506
	Цахим санд оруулах	10	95,502	955,020
	Нийт	118	95,502	11,269,236

Дээрхээс харахад хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх хүсэлтийг жилд нэг удаа шийдвэрлэх бөгөөд энэ үйл ажиллагааг бүртгэх мэдээлэл дамжуулах үйл ажиллагаанд нийт 11,369,236 минут зарцуулагдана. Үүнийг хүний нөөцийн хэрэгцээгээр тодорхойлж үзвэл нийт **117** албан хаагч шаардлагатай байна.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ/минут	Нэг жилд шаардагдах ажлын цаг/минут	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/

¹⁸ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд” сэдэвчилсэн судалгаа. ҮСХ, 2010 он.
https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Hugjliin_berhsheel_MGL.pdf&ln=Mn

Төрийн захиргааны байгууллага	11,269,236 минут	96000	117,3
-------------------------------	------------------	-------	-------

Гэхдээ улсын хэмжээнд хэрэгжих уг арга хэмжээг хүн амын суурьшил, тархалттай холбож үзвэл хүний амын талаас илүү хувь оршин суудаг нийслэлд 58,6, аймаг тус бүрт 2,7 хүний нөөц шаардагдахаар байна.

Хувийн туслахын үйлчилгээтэй холбоотой буюу ХБХ-ийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэхтэй холбоотой журам, шалгуур, үнэлгээ¹⁹ ХНХСайдын А/187 тоот тушаалаар 2021 онд шинэчлэн баталсан. Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зардлын хэмжээг тодорхойлох аргачлалд санал авч бөгөөд уг аргачлалд зааснаар ХБХ хүнд нэг сарын 150 цаг хүртэл хугацаагаар, 1 цагийн 3500 төгрөгийн хөлсөөр тоохон хувийн туслахын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн байна.²⁰ Дээрх үйлчилгээг үзүүлэх 1 цагийн зардал нь 3500 төгрөг байх ба үүнээс 3150 төгрөгийг төрөөс 350 төгрөгийн үйлчлүүлэгч өөрөө гаргахаар зохицуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд холбогдох журамд зааснаар хувийн туслахын ажлын цаг хамгийн ихдээ 8 цаг байна. Харин ХБХ-нд хамгийн багадаа 2 цагийн үйлчилгээ үзүүлэх байдлаар хувийн туслахын үйлчилгээний зардлыг тоохон нэг хүнд ногдох зардлыг 7000 төгрөг байна гэх тойм тооцооллыг гаргалаа. Мөн хувийн туслахын үзүүлэх 15 төрлийн үйлчилгээний²¹ давтамж харилцан адилгүй, дундаж хэмжээг тодорхойлох боломжгүй. Иймээс ХБХ-ийг сургалтын байгууллагад хүргэх, авах үйлчилгээ үзүүлэх нэг жилийн хугацаан дахь давтамжийг БСШУССайдын 2020 оны 05 дугаар сарын 2-ны өдрийн А/244 тоот тушаалаар баталсан 2021-2022 оны “Хичээлийн жилийн бүтэц”-д заасан хугацааг дундажлан 231 өдөр байхаар тооцов.²²

Хувийн туслахын гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолдлын тоо	Давтамж	Тариф	Зардал
ХБ оюутныг сургалтын байгууллагад хүргэх, авах	Гэрээс нь сургалтын байгууллагад хүргэх	60	1	231	3500	808,500
	Сургуулиас гэрт нь хүргэх	60	1	231	3500	808,500
	Нийт	120	1		3500	1,617,000

Нэг хүнд хамгийн бага хэмжээнд ногдох зардал буюу суралцагчийг нэг жилийн хугацаанд хичээлийн 231 өдөр сургалтын байгууллагад хүргэх, авах зардал болох 1,617,000 төгрөгийн зардлыг 18-аас дээш насны ХБХ-ий тоогоор үржүүлж үзвэл **1,617,000 төгрөг * 95,502 суралцагч = 154,426,734,000** төгрөг байна.

¹⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389877792661>

²⁰ Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмын Нэгдүгээр хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зардлын хэмжээг тодорхойлох аргачлал”

²¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389877847601&showType=1>

²² Хичээлийн жилийн бүтэцд зааснаар 1-3 ангийн сурагчид 32 7хоног, 4-5 ангийн сурагчид 33 7 хоног, 6-12 ангийн сурагчид 34 7 хоног хичээллэхээр тусгасан.

1.2.6. Брайль бичгээр боловсрол эзэмших, мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь

Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Харааны бэрхшээлтэй хүн брайль бичгийг ашиглан боловсрол эзэмших эрхтэй бөгөөд бүх түвшний боловсролын сургалтын байгууллага харааны бэрхшээлтэй хүн брайль бичиг болон бусад технологи ашиглан боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.” гэх зохицуулалтыг шинээр тусгажээ.

Энэхүү үүрэгжүүлсэн зохицуулалтын хүрээнд өмчийн бүх хэлбэрийн бүх шатны боловсролын байгууллагууд үүрэг хүлээнэ.

Энэ хэсэгт хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан мэдээлэл **авах нөхцөлийг бүрдүүлэх** үүргийг хэрэгжүүлэхэд төрийн өмчийн боловсролын байгууллагад үүсэх хүний нөөцийн зардлыг стандарт үйл ажиллагааны загвараар тооцолно.

Тохиолдлын тоог тогтоохдоо 4740 улсын төсвийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, 393 төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар²³ болон өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 1454 СӨБ-ын байгууллага, 839 ЕБС-иар тооцон нийт 7426 байгууллагад хамаарна гэж үзлээ.

Давтамжийн тоог тогтоохдоо тухайн байгууллагад хамаарах мэдээллийг хагас жилд 1 удаа шинэчлэнэ гэж үзэн 1 жилд 2 удаагийн давтамжтай байна гэж, харин брайль үсгээр байршуулах мэдээллийн хэмжээ дунджаар 10 хуудас байхаар баримжаалан тооцов.

Хүлээсэн үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа/ минут	Давтамж	Хүний нөөц
Хуулийн төслийн “12.1.Харааны бэрхшээлтэй хүн брайль бичгийг ашиглан боловсрол эзэмших эрхтэй бөгөөд бүх түвшний боловсролын сургалтын байгууллага харааны бэрхшээлтэй хүн брайль бичиг болон бусад технологи ашиглан боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.	Брайль бичгээр мэдээллээр хангах	Үүрэгтэй танилцах	15	2	30
		Мэдээлэл боловсруулах	480	2	960
		Мэдээллийг нягтлах, алдааг засах	15	2	30
		Мэдээллийг хэвлүүлэх захиалга өгөх	20	2	40
		Мэдээллийг хэвлэлтэд шилжүүлэх	5	2	10
		Хэвлэсэн материалыг хүлээн авах	30	2	60
		Мэдээллийг байршуулах	5	2	10

²³ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо, улирал, хариуцлагын хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр. Эх сурвалж: https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2600_009V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=5&01_select_all=0&01SingleSelect=6_7&YearQ_select_all=0&YearQSingleSelect=202102&viewtype=table Сүүлд нэвтэрсэн 2021.09.24

Нийт			570	2	1140
-------------	--	--	------------	----------	-------------

Дээрх хүснэгтэд ХБХ-ий эрхийг хангахын тулд брайль үсгээр мэдээлэл бэлтгэх үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг гүйцэтгэхэд нэг байгууллага шаардагдах нийт ажлын цагийг жишиг байдлаар тооцов. Үүнээс харахад тухайн байгууллага мэдээлэл бэлтгэж, брайль бичгээр хэвлүүлэн нийтлэхэд **0,02** хүний нөөцийн шаардлага үүсч байгаа нь шинээр орон тоо үүсгэлгүйгээр дотоод зохион байгуулалтын хүрээнд гүйцэтгэж болох байна.

Харин бэлтгэсэн мэдээллээ брайль үсгээр хэвлүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэх шаардлага үүснэ. ХНХЯ-наас ирүүлсэн мэдээллээс харахад нэг нүүр материалыг дан брайль үсгээр хэвлүүлэхэд 400 төгрөгөөр, брайль, крилл үсгээр хослуулан хэвлүүлэхэд 800 төгрөгийн өртөгтэй байна. Үүнээс харахад нэг байгууллага хагас жил тутам 10 хуудас мэдээллийг зөвхөн брайль үсгээр хэвлүүлэхэд 8000 төгрөгийн зардал гарах төлөвтэй байна. Үүнийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч байгууллага, ТӨҮГ болон СӨБ-ийн байгууллага, ЕБС-ийн түвшинд авч үзвэл нийт 59,408,000 төгрөгийн зардал гарах байна.

Хуулийн төслийн 12.1-д заасан үүргийг хэрэгжүүлэхэд үүсэх бусад зардлыг тооцож үзвэл:

Үйл ажиллагаа	Хэвлэлийн зардал	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Брайль үсгээр хэвлүүлэх	4000 төгрөг	7426	2	14852	59,408,000

Дээрх тооцооллоос тухайн байгууллагад холбогдолтой 10 хуудас мэдээллийг брайль үсгээр хэвлүүлэн нийтлэхэд шаардлагатай

- Хүний нөөцийн хэрэгцээ **0,02**
- Нэг удаагийн буюу бусад зардал **8000** төгрөг, нийт төрийн байгууллагуудын хэмжээнд **59,408,000** төгрөгийн зардал үүсгэхээр байна.

Хуулийн төслийн 12.1 дэх заалтын хүрээнд бүх шатны боловсрол, сургалтын байгууллага брайль үсэг ашиглан боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ гэх зохицуулалтын зардлын тооцоог гаргахад шаардлагатай тоо баримт, тухайлбал нэг СӨБ-ын байгууллага, мэргэжлийн болон их дээд сургуулийн түвшинд ямар сурах бичиг, гарын авлага, сургалтын материалыг нэн шаардлагатай гэж үзэн брайль үсгээр хэвлэсэн байх, багшийн тараах материалд хамаарах эсэх зэрэг нэн шаардлагатай мэдээлэл хангалтгүй байх тул тооцох боломжгүй юм.

1.2.7. Халаалт, түлшний мөнгөн тусламж үзүүлэх насны хязгаарыг 18 болгон нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь

Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтад “байнгын асаргаа шаардлагатай **18 хүртэлх** насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа

бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;” гэж заасан.

Хуулийн төлийн дээрх заалтын хүрээнд 16-18 насны иргэдэд жил бүр нэг удаа олгогдох халаалт, түлшний зардлыг олгох шаардлага үүснэ. Энэ нь нэг талаас хүний нөөцийн зардал, нөгөө талаас Нийгмийн халамжийн санд санхүүжилтийн ачаалал үүсгэхээр байгаа тул эдгээр зардлыг тооцоолно.

Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх үндсэн байгууллага нь Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын харьяа нэгжүүдэд, сум, хорооны нийгмийн халамжийн ажилтан болон аймаг, дүүргийн нийгмийн халамжийн хэлтэс байх юм. Иймээс ХХҮГ-ын өргөдөл хүлээн авахтай холбоотой үүсэх хүний нөөцийн хэрэгцээг тооцно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан 17 төрлийн хөнгөлөлт, тусламжийг хэрэгжүүлэх зорилгоор ЗГ-ын 2017 оны 197 тогтоолын 5р хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журамд зааснаар халаалт, түлшний мөнгөн тусламж хүсэж буй ХБХ 7 төрлийн баримт бичиг бүрдүүлэх шаардлага тавьсан.”²⁴

Хүлээсэн үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа/ минут	Давтамж	Хүний нөөц
Хуулийн төслийн 22.1.1-д заасан “байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны ... хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох	Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх	Баримт бичиг хүлээн авах	10	1	10
		Баримт бичгийг нягтлах	25	1	25
		Холбогдох байгууллагад хүргүүлэх	80	1	80
		Бүртгэл хөтлөх	10	1	10
		Мэдээллийн санд оруулах	10	1	10
		Өргөдөл гаргагчид хариу мэдэгдэх	10	1	10
		Тэмдэглэгээ хийх	5	1	15
Нийт			150	1	150

²⁴ ЗГ-ын 2017 оны 197 тогтоолын 5р хавсралт ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ: Гурав. Тусламж, хөнгөлөлт авахад бүрдүүлэх баримт бичиг
3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.1-д заасан тусламж авах хүсэлт гаргахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ: 3.1.1. өргөдөл (маягтын дагуу); 3.1.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт; 3.1.3. 16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ, хуулбарын хамт; 3.1.4. хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэх, хуулбарын хамт; 3.1.5. аймаг, дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хуулбар; 3.1.6. хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоосон аймаг, дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн хуулбар; 3.1.7. иргэнд байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай болохыг тогтоосон сум, тосгоны эрүүл мэндийн төвийн ерөнхий эмч, аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын тодорхойлолт. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/7964?lawid=12824>

Үүнээс харахад байнгын асаргаа шаардлагатай **18 хүртэлх** насны хөгжлийн бэрхшээлтэй нэг хүн халаалтын болон түлш худалдан авахад зориулсан мөнгөн тусламж хүссэн өргөдөл гаргасан бол түүнийг шийдвэрлэж буй ХХҮГ-ын мэргэжилтэнд 150 минутын ажлын ачаалал үүсч байна.

Хуулийн төсөлд тусгаснаар мөнгөн тусламжийг 1 жилд 1 удаа олгох тул давтамжийн тоо 1 байна. Харин тохиолдлын тоог 2020 онд 17 настай 705, 18 настай 829 ХБХүүхэд байна гэх ХНХЯ-наас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн 1534 байна гэж дундажлан тооцов.

Үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт	Нийт зардал	Хүний нөөц
Өргөдөл шийдвэрлэх	150	1534	1	1534	230,100	2,4

Үүнээс харахад ХХҮГ-т 17-18 насны 1534 ХБХүүхдийн халаалт, түлшний зардал хүссэн өргөдлийг шийдвэрлэх үйл ажиллагаанд 230,100 минут буюу 3835 цагийн ачаалал үүсгэнэ. Энэ нь **2,4 хүний нөөцийн хэрэгцээг** үүсгэж байна.

2023 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүнд нэг жилд 1 удаа олгох халаалтын болон түлш худалдан авахад зориулсан мөнгөн тусламжийн хэмжээ 140,000 төгрөг байна.²⁵ Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд Нийгмийн халамжийн санд нэг жилд дунджаар 1534 ХБХүүхэд*140,000 төгрөг= **214,760,000** төгрөгийн ачаалал үүсгэхээр байна.

1.2.8. Нийслэлээс 500 км-ээс дээш зайд алслагдсан нутгаас нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэхтэй холбогдон гарах зардлыг тодорхойлох нь

Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.1.5-д “нийслэлээс 500 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг **байнгын асаргаа шаардлагатай** хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд хот хоорондын зорчигч тээврийн жишиг үнийг үндэслэн унааны зардлыг жилд нэг удаа 100 хувь, асран хамгаалагчид 50 хувийг нөхөн олгох;” гэж заасан нь одоо хэрэгжиж буй сум аймгаас нийслэлд ирж, буцах унааны зардлын 75%-ийг олгодог хувь хэмжээ, энэ үйлчилгээг авах эрхтэй ХБХ-ий хамрах хүрээнд өөрчлөлт оруулсан .

Одоо хэрэгжиж буй хуулийн заалтын хүрээнд Улаанбаатар хотоос 1000-аас дээш километрийн зайд орших Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан, Өмнөговь аймгийн ХБХ-ий замын зардлын 75%-ийг нөхөн олгодог байсан бол хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан зохицуулалтын дагуу Улаанбаатар хотоос 500-аас дээш километрийн зайд орших Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Архангай, Дорноговь, Дундговь аймгийн зарим сумдын²⁶

²⁵ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ <http://www.gadpwd.gov.mn/uploads/files/брошур%20эх%20НХ-converted-converted.pdf>

²⁶ Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 190 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн чиглэл”-д заасан хэмжээг ашиглав. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/8011?lawid=12861>

байнгын асаргаа шаардлагатай ХБХ-ий эмчилгээ хийлгэх, шинжилгээ өгөхөөр нийслэлд ирсэн зардлыг жилд 1 удаа 100%, түүний асран хамгаалагчийн зардлын 50%-ийг хариуцахаар болж байна. Энэ судалгааны хүрээнд нийслэлээс 500 км-ын зайд орших аймаг, сумдын байнгын асаргаа шаардлагатай ХБХ-ий тоог нарийвчлан гаргах боломжгүй тул аймгийн хэмжээнд бүртгэгдсэн ХБХ-ий тоог²⁷ ашиглав. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны төвөөс Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний хүрээн хийсэн “Байнгын асаргаа шаардлагатай болон тэднийг асарч буй иргэнд олгох мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ” судалгааны тайланд дурдсанаар 2017 онд 39,5 мянга буюу нийт халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 4,2 хувийг эзлэх байнгын асаргаа шаардлагатай иргэнд 8,716,6 сая төгрөг зарцуулсан байна.²⁸ Тодруулбал, халамжийн үйлчилгээний хүрээнд олгосон нийт тэтгэвэр, тэтгэмжийн 2,9 хувийг байнгын асаргаа шаардлагатай иргэнд, 11,1 хувийг байнгын асаргаа шаардлагатай иргэнийг асарч буй иргэнд олгосон мөнгөн тэтгэмж эзэлдэг байна. Үүнээс харахад суурь тоон үзүүлэлтээр 39,5 мянган байнгын асаргаанд байдаг ХБХ, мөн тооны асран хамгаалагчийг авч үүнээс хуулийн төслийн 21.1.9-т заасан шаардлага хангасан ХБХ-ий тоог гаргахыг зорьно.

Аймгуудын ХБХ-ий тоог авч үзвэл:

Аймгийн нэр	ХБХ-ий тоо	Аймгийн нэр	ХБХ-ий тоо
Архангай	3669	Орхон	4264
Баян-Өлгий	4245	Өвөрхангай	4259
Баянхонгор	3432	Өмнөговь	2189
Булган	2356	Сүхбаатар	2707
Говь-Алтай	3116	Сэлэнгэ	4980
Говьсүмбэр	748	Төв	3303
Дархан-Уул	4474	Увс	4629
Дорноговь	2720	Улаанбаатар	35556
Дорнод	4269	Ховд	2866
Дундговь	1851	Хөвсгөл	6023
Завхан	3721	Хэнтий	3022
нийт			108399

Дээрхээс харахад одоо хэрэгжиж буй хуулийн хүрээнд Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан, Өмнөговь аймгийн нийт 20766 ХБХ-ий зардлыг хариуцах үүрэг хүлээж байсан бол хуулийн төсөлд тусгасан шинэ зохицуулалтаар Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Архангай, Дорноговь, Дундговь аймгийн нийт 45437 ХБХ-ээс байнгын асаргаа шаардлагатай ХБХ-ий замын зардлыг 100%, түүний асран хамгаалагчийн замын зардлыг 50% -иар тооцож нэг жилд нэг удаа олгохоор тусгажээ.

Нийслэлээс 500 километрээс хол зайд байрлах дээр дурдсан 13 аймгийн байнгын асаргаа шаардлагатай ХБХ-ий тоог энэ хэсэгт цуглуулсан тоон мэдээлэлд үндэслэн

²⁷ ХНХЯ-наас ирүүлсэн мэдээллийг ашиглав.
²⁸

[Байнгын асаргаа шаардлагатай болон тэднийг асарч буй иргэнд олгох мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ 2 018.pdf \(institute.gov.mn\)](#)

тогтоохыг зорьж байгаа бөгөөд нийт ХБХ-ий дунд байнгын асаргаа шаардлагатай иргэдийн эзлэх хувийг 36 хувь гэж үзэн энэ хэмжээг 13 аймгийн түвшинд дүйцүүлж тооцоход ойролцоогоор 16,357 байнгын асаргаа шаардлагатай иргэн болон мөн тооны асран хамгаалагчийн замын зардлыг хууль заасан хэмжээгээр олгох боломжтой гэж үзэн тохиолдлын тоо болгон авлаа.

ХХҮГ-ын нийгмийн халамжийн мэргэжилтнүүдэд байнгын асаргаа шаардлагатай ХБХ-ий нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэсэн замын зардлаа нөхөн олгуулахтай холбоотой гаргасан өргөдлийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа болон хүний нөөцийн хэрэгцээг тооцож үзье.

Хүлээсэн үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа/ минут	Давтамж	Хүний нөөц
Хуулийн төслийн 21.1.9-д нийслэлээс 500 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд хот хоорондын зорчигч тээврийн жишиг үнийг үндэслэн унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох	Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх	Баримт бичиг хүлээн авах	10	1	10
		Баримт бичгийг нягтлах	25	1	25
		Холбогдох байгууллагад хүргүүлэх	80	1	80
		Бүртгэл хөтлөх	10	1	10
		Мэдээллийн санд оруулах	10	1	10
		Өргөдөл гаргагчид хариу мэдэгдэх	10	1	10
		Тэмдэглэгээ хийх	5	1	15
Нийт			150	1	150

Үүнээс харахад ХБХ-ий нийслэлд эмчлүүлэх, шинжилгээ хийлгэсэн ирж, очих замын зардлаа нөхөн олгуулахтай холбоотой гаргасан нэг өргөдлийг шийдвэрлэхэд ХХҮГ-ын мэргэжилтэнд 150 минутын ажлын ачаалал үүсэхээр байна.

. Хуулийн төсөлд тусгаснаар замын зардлыг хот хоорондын зорчигч тээврийн жишиг үнийг үндэслэн 1 жилд 1 удаа олгох тул давтамжийн тоо 1 байна. Харин тохиолдлын тоог Улаанбаатар хотоос 500 км-ээс зайд орших аймгуудын байнгын асаргаа шаардлагатай нийт ХБХ-ий тоо болон түүний асран хамгаалагчийн тоогоор тооцов. Гэхдээ хуулийн төслийн 21.1.9-д заасан хуулийн шаардлага хангасан ХБХ-ий тооноос одоо шийдвэрлэж буй энэ төрлийн өргөдлийн тоог хасах буюу одоо хөнгөлөлтөд хамрагдаж буй аймгуудын 20766 ХБХ-ий тоог хассанаар 11,948 хүнд шинээр үйлчилгээ үзүүлэх шаардлага үүснэ гэж тооцов.

Үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Өргөдөл шийдвэрлэх	150	11,948	1	11,948	3,700,650

Дээрх тооцооллоос харахад ХХҮГ-т ХБХ-ий нийслэлд эмчлүүлэх, шинжилгээ хийлгэсэн ирж, очих замын зардлаа нөхөн олгуулахтай холбоотой гаргасан өргөдлийг

шийдвэрлэх үйл ажиллагаанд 1,792,200 минут буюу 29,870 цагийн ачаалал үүсгэнэ. Энэ нь **18,6 хүний нөөцийн хэрэгцээг** үүсгэхээр байна.

Харин олгох зардлын тухайд байнгын асаргаатай хүний зардлыг 100 хувь, асран хамгаалагчийн зардлыг 50 хувиар тооцож олгох болсонтой холбогдуулан замын зардлыг хот хоорондын зорчигч тээврийн жишиг үнийг үндэслэн 1 жилд 1 удаа олгох тул давтамжийн тоо 1 байна. Улаанбаатар хотоос 500 км-ээс зайд орших аймгуудын байнгын асаргаа шаардлагатай ХБХ-ий тоог 16,357, мөн түүний асран хамгаалагчийн тоог 16,357 байхаар тохиолдлын тоог тогтоов.

Замын зардал нөхөн олгохтой холбоотой үүсэх зардлыг олгох жишиг үнийг Зам тээврийн сайдын 2022 оны “Автотээврийн жишиг тариф шинэчлэн батлах тухай” А/233 дугаар тушаалаар баталсан тарифын дагуу нэг хүн зорчих нэг км-ын өртгийг 75-150 төгрөрөөр тогтоосон.²⁹ Иймээс шинэчлэн баталсан тарифын дундаж хэмжээнд үндэслэн Нийгмийн халамжийн санд замын зардал олгохтой холбоотой үүсэх ачааллыг тооцлоо.

Ингэхдээ замын зардал тооцох дундаж хэмжээг нийслэлээс 500-999 км хүртэлх зайны арифметик дундаж хэмжээ болох 749,1 км-ээр, 1 км замын зардлын дундаж тарифыг 112,5 төгрөгөөр тус тус тооцов.

Үйл ажиллагаа	Жишиг тариф/км	Замын дундаж урт	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Замын зардал 100%	112,5 төгрөг	749,1 км	16,357	1	16,357	1,378,465,728
Замын зардал 50%	112,5 төгрөг	749,1 км	16357	1	16,357	689,232,864
Нийт						2,067,698,592

Үүнээс харахад байнгын асаргаа шаардлагатай ХБХ-нд олгох дундаж зардал **84,273, асран хамгаалагчид олгох дундаж зардал 42,132** төгрөг байх ба үүнийг тоон үзүүлэлтэд харьцуулж үзвэл **2,067,698,592** төгрөгийн ачаалал Нийгмийн халамжийн санд үүсэхээр байна.

Гэхдээ хуулийн төсөлд “байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд” энэ төрлийн зардлыг олгохоор заасан нь нийслэлээс 500 км-ээс дээш зайд байнга оршин суугаа байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр энэ төрлийн зардлыг жил бүр нөхөн авахгүй байх нөхцөл үүссэн. Тухайлбал, 2020 онд орон нутгаас нийслэлд ирж эмчлүүлсэн 2354 ХБХ-нд 619,420,860 төгрөгийн замын зардал олгожээ.³⁰ ХНХЯ-наас ирүүлсэн мэдээллээс харахад 2020 онд нийслэлээс 1000-аас км-т алслагдсан аймаг, суманд байнга оршин суугаа 20766 ХБХ-ий 11%-д замын зардал олгосон байх ба 1 хүнд ногдох зардлын хэмжээ дунджаар 263,135 төгрөг байсан байна.

Дээрх тоо мэдээлэлд үндэслэн нийслэлээс 500-аас дээш км-т алслагдсан аймаг, суманд байнга оршин суугаа шинээр нэмэгдэж буй ХБХ-ий 11% буюу нэг жилд хамгийн

²⁹ Зам тээврийн сайдын 2022 оны “Автотээврийн жишиг тариф шинэчлэн батлах тухай” А/233 дугаар тушаал. Эх сурвалж: <https://mrt.d.gov.mn/i/3154>

³⁰ ХНХЯ-ны мэдээллээс

багадаа 1801 хүн, асран хамгаалагчийн хамт эмчилгээ, шинжилгээнд хамрагдахаар нийслэлд ирэх, буцах зардлыг олгох шаардлага үүсэх ба үүний санхүүжилтийн хэмжээ **151,796,741 төгрөг, асран хамгаалагчийн зардалд 75,890,265** төгрөг зайлшгүй шаардагдана гэж үзлээ.

Хуулийн төслийн 22 дүгээр зүйлийн 22.1.1 дэх заалтын хэрэгжилтийг хангахад дараах зардал үүсэх магадлалтай байна.

- ХХҮГ-т ирүүлэх хүсэлтийн тоо буурч байгаатай холбогдуулан хүний нөөцийн зардал шинээр үүсэхгүй
- НХСангаас **2,067,698,592** төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна.

1.2.9. Орон сууцны тохируулга, хүртээмжийг сайжруулахад олгох холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтад хөгжлийн бэрхшээлтэй хүний оршин суугаа орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах зорилгоор нэг удаагийн дэмжлэг үзүүлэхээр тусгасан байна.

ХБХ-ий оршин суугаа орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах нэг удаагийн дэмжлэг авах өргөдлийг шийдвэрлэх ажиллагааг ХХҮГ хэрэгжүүлнэ гэж үзэн хүний нөөцийн хэрэгцээг тогтоохдоо өмнөх хэсэгт гаргасан тооцоололд үндэслэн энэ төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжилтэнд 150 минутын ажлын ачаалал үүснэ гэж үзэв.

Хуулийн төсөлд тусгаснаар энэ төрлийн дэмжлэгийг ХБХ-д амьдралын туршид 1 удаа олгох тул давтамжийн тоог тогтоохдоо монгол хүний дундаж наслалтын хэмжээг харгалзан 0,014 байна гэж үзсэн. Харин тохиолдлын тоог эхний ээлжинд энэ төрлийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай харааны, хөдөлгөөний, оюуны бэрхшээлтэй иргэдийн тоогоор тооцов.

Үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /Минут/	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Өргөдөл шийдвэрлэх	150	106,169	0,014	1061,6	159,253

Дээрх тооцооллоос харахад ХХҮГ-т ХБХ-ий оршин суугаа орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах нэг удаагийн дэмжлэг авах өргөдлийг шийдвэрлэх үйл ажиллагаанд 129,255 минут буюу 19,906 цагийн ачаалал үүсгэнэ. Энэ нь **12,4 хүний нөөцийн хэрэгцээг** үүсгэж байна.

Хууль эрх зүйн хувьд шинээр зохицуулагдах энэ харилцааны зардлыг тооцоход шаардлагатай тоон утга байхгүй тул үүнтэй ижил төстэй үйлчилгээ буюу улсын хэмжээнд хэрэгжүүлсэн гэр хорооллыг иргэдийн байр орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор олгосон “Ногоон зээл”-ийн хэмжээг баримжаалан тооцох боломжтой байна. Төрийн банк, Хаан банк зэрэг санхүүгийн байгууллагаас олгож буй зээлийн хэмжээнээс харахад орон сууцны нөхцөлийг сайжруулах зориулалттай зээлийн хэмжээ 3-20 сая хүртэл төгрөг байх ба орон сууцны нөхцөлийг сайжруулах зорилгоор олгож буй зээлийн дундаж

хэмжээ 15 сая төгрөг байна. Иймээс хуулийн төсөлд тусгасан нэг удаагийн дэмжлэгийн хэмжээг 15 сая төгрөг байхаар тооцож зарлыг тооцов.

ХБХ-ий оршин суугаа орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах нэг удаагийн дэмжлэг өмнө олгож байгаагүй тул тохиолдлын тоог 2021 онд бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн тоогоор буюу 106,169³¹ байхаар тооцов.

Үйл ажиллагаа	Дэмжлэгийн хэмжээ	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах нэг удаагийн дэмжлэг авах	15,000,000	106,169	1	106,169	1,592,535,000

Дээрхээс харахад ХБХ-ий орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах нэг удаагийн дэмжлэгийг олгоход **1,592,535,000** төгрөгийн ачаалал Нийгмийн халамжийн санд үүсэхээр байна.

1.2.10. Орон сууцаар хангахтай холбогдон гарах хүний нөөцийг тодорхойлох нь

Хуулийн 21.3.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хамруулах орон сууц, орон байрны хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймаг, нийслэлийн Засаг даргын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний жил бүрийн төсөвт тусгахаар заасан.

Төрийн орон сууцны хөтөлбөрийн хүрээнд баригдаж буй орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд тэгш, хүртээмжтэй хуваарилах ажлыг хүн амыг хямд өртөгтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ /цаашид ТОСК гэх/ хариуцан ажиллаж байна. Тус корпораци нь Хөгжлийн банк, Бонд болон бусад санхүүжилтээр 2012-2016 онд Улаанбаатар хотод Буянт-Ухаа 1, 2 дугаар хороолол³² барих төслийг хэрэгжүүлснээр нийт 3384 айлын орон сууц шинээр бий болгосон бол 16 аймагт 900 орчим айлын орон сууц ашиглалтад орууж эдгээр орон сууцны үнийг зах зээлийн үнээс хамгийн хямдаар тогтоож, тогтоосон квотын дагуу хуваарилах ажлыг зохион байгуулжээ.³³ Энэ хөтөлбөрийн хүрээнд баригдсан орон сууцанд төрийн албан хаагч, залуу гэр бүл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гээд зорилтот бүлгийн иргэдийг хамруулсан байна. Ингэхдээ Буянт-Ухаа 1 хорооллын 1 метр квадратын үнэ 1,280,000 төгрөг, Буянт-Ухаа 1 хорооллын 1 метр квадратын үнэ 1,350,000 төгрөгөөр борлуулсан, харин түрээсийн үнийг 1 метр квадрат тутамд Улаанбаатарт 6500

³¹Статистикийн мэдээллийн нэгдсэн сан:

https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_3900_004V1&Disability_select_all=0&DisabilitySingleSelect=_1&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021&viewtype=table

³² 28 барилгаас бүрдсэн 1764 айлын орон сууц бүхий буянт-ухаа-1 хороолол, 48 барилгаас бүрдсэн 1620 айлын орон сууц бүхий буянт-ухаа-2 хорооллыг барьж ашиглалтад оруулсан байна.

³³ тоск төүг-ын барилгын инженер ууганбаяраас авсан мэдээлэл

төгрөг, орон нутагт 4500-5500 төгрөг байхаар тогтоож байжээ. Хэдийгээр өнгөрсөн хугацаанд 40000, 100000 айлын орон сууц барих төсөл, хөтөлбөрийн тухай яригдаж байсан боловч ажил болж хэрэгжсэн зүйл алга байна. ТОСК ТӨҮГ нь 2016 оноос хойш төрийн хөрөнгөөр орон сууц барих ажил хийгээгүй бөгөөд одоогоор 2020-2024 онд 5040 айлын орон сууц бүхий “Солонго -1, 2 орлогод нийцсэн орон сууцны хороолол барих төсөл”-ийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.³⁴

Дээрх мэдээллээс харахад 2012 оноос хойш 10 жилийн хугацаанд ТОСК-ТӨҮГ-ын хариуцсан буюу төрийн оролцоотой баригдаж буй орон сууцны тоог авч үзвэл нэг жилд дунджаар Улаанбаатар хотод 380, орон нутагт 90 орчим буюу 1 аймагт 4,2 орон сууц ашиглалтад оруулсан байна. Эдгээр орон сууцны 10%-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр борлуулах болон түрээслэх ажлыг журмаар зохицуулан³⁵ ажилласан байна.

Үүнээс үзэхэд нийт ашиглалтад орж буй орон сууцны 2% буюу нийслэлд нэг жилд дунджаар 7,6 орон сууц, орон нутагт 1,8 орон сууцыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд буцалтгүй болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно гэж үзвэл түүнд шаардлагатай зардлыг тооцох шаардлага үүснэ. Харин орон сууцнаас бусад орон байраар хангахад шаардлагатай хөрөнгийг аймаг, нийслэлийн төсөвт суулгах асуудлыг тодорхойлохуйц мэдээ, мэдээлэл байхгүй тул уг зардлын тооцоолох боломжгүй байна.

Цаашид төрийн болон орон нутгийн хөрөнгөөр баригдах орон сууцны тоо, түүний үнийн хэлбэлзлийг тооцох боломжгүй тул дээр дурдсан мэдээлэлд үндэслэн хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.2.2 дахь заалтын үр дүнд үүсэх зардлыг тооцов.

Хөнгөлөлттэй нөхцөлөөр болон түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлтэй ХБ иргэдийн өргөдлийг шийдвэрлэх ажиллагааг энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэгч ТОСК ТӨҮГ хариуцан ажиллаж ирсэн тул өргөдөл хүлээж авах, шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүний нөөцийн хэрэгцээ шинээр үүсэхгүй гэж үзлээ.

№	Байршил	тоо	Орон сууцны тоо	Орон сууцны дундаж үнэ	Нийт үнэ
1	Нийслэл	1	380	60,750,000	23,085,000,000
2	Аймаг	21	4,2	60,750,000	5,358,150,000
	Нийт				28,433,150,000

Шинээр баригдсан орон сууцны 2%-ийг худалдан авах зардлыг жил бүр төсөвт эсхүл тодорхой санд байршуулах зохицуулалт хуулийн төсөлд бий. Шинээр баригдаж буй орон сууцны хэмжээнээс харахад иргэдийн төлбөрийн чадвар болон бусад шаардлагад нийцсэн хамгийн эрэлттэй орон сууц 31-60 м² хэмжээтэй байна.³⁶ Иймээс орон сууцны зай талбайг дунджаар 45 м² гэж, 1 м² талбайн үнийг 2019 оны жишгээр 1,350,000 төгрөг байхаар тооцож

³⁴ <https://tosk.gov.mn/?p=5372>

³⁵ Засгийн газраас зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөтөлбөрийн хүрээнд баригдсан “буянт-ухаа 1” хорооллын орон сууцанд иргэдээс захиалга авах журам ЗГ-ын 2014 оны 36-р тогтоол. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/6240?lawid=9810>

³⁶ Улаанбаатар хотын орон сууцны нөхцөл байдлын тойм судалгаа (2010-2018). эх сурвалж: http://mirim.mn/wp-content/uploads/2020/10/mirim_улаанбаатар-хотын-орон-сууцны-нөхцөл-байдлын-тойм-судалгаа.pdf

үзэхэд улсын хэмжээнд буюу нийслэл болон 21 аймгийн хэмжээнд хамгийн багадаа 28,433,150,000 төгрөгийн 470 орчим орон сууцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохоор байна.

1.2.11. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбоотой гарах зардлыг тодорхойлох нь

Хуулийн төслийн 41 дүгээр зүйлд ХБХ-ий эрхийг хамгаалах салбарын ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор төвөөс алслагдсан байдлыг харгалзан нэмэгдэл цалин, урамшуулал авах, орон сууц барих эсхүл худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл, тусламжид хамрагдах, ХБХ-ий эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний салбарын ажилтанд ажилласан 5 жил тутамд 6 сарын цалинтай тэнцэх 1 удаагийн мөнгөн урамшуулал олгох болон хуульд заасан бусад баталгаа эдлэх эрхийг шинээр тусгаж өгсөн байна.

ХНХЯ-наас авсан мэдээллээс харахад ХБХ-ий эрхийг хамгаалах, үйлчилгээг сайжруулах, бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв /6 аймаг/-д нийт 808 албан хаагч ажиллаж байна.³⁷

Хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасан нийгмийн баталгааны төрлүүдээс төрд үүсэх ачааллыг тооцох боломжтой зохицуулалт нь 41.1.1 дэх заалтын дагуу төрийн үйлчилгээний албан хаагчид олгох ажилласан 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн мөнгөн тэтгэмж байна.

Нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн энэ заалтын хүрээнд ХБХ-ий эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний албан хаагчид 5 жил тутамд мөнгөн урамшуулал олгохтой холбоотой үүсэх зардлыг тооцохдоо үндсэн цалингийн хэмжээг ЗГ-ын 2024 оны 488 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан төрийн үйлчилгээний байгууллагын албан хаагчийн цалингийн зэрэглэлийн дунджаар **1,702,800 төгрөг** байна гэж үзсэн.

Тохиолдлын тоог тогтоохдоо ХНХЯ-наас ирүүлсэн 808 албан хаагчийн тоог суурь үзүүлэлт болгон авсан, гэхдээ үүнээс энэ салбарт хөдөлмөр эрхэлж буй төрийн захиргааны албан хаагчдын тоог хасаж тооцох нь зүйтэй бөгөөд энэ тоо тодорхойгүй тул нийт албан хаагчдын 10 хувийг төрийн захиргааны албан хаагч эзэлнэ гэж үзээд **тохиолдлын тоог 728** байх ба давтамж нь 5 жил тутамд нэг удаа олгох тул 0,2 байна.

Эрх зүйн зохицуулалт	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
41.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний салбарын ажилтанд ажилласан 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх 1 удаагийн мөнгөн урамшуулал олгох.	728	0,2	145,6

³⁷ ХНХЯ-наас ирүүлсэн мэдээлэл. 2023.04.20-ны өдөр

Дээрх тооцооллоос харахад ХБХ-ий эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний албан хаагчид 5 жил тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээ 4,801,650 төгрөг байх бөгөөд нийт олгох мөнгөн урамшууллын хэмжээ **699,120,240** төгрөг байна. Энэ салбарт ажиллаж буй үйлчилгээний албан хаагчдын ажилласан жилээс шалтгаалан жилд олгох мөнгөн урамшууллын хэмжээ өөрчлөгдөх боломжтой. Түүнчлэн хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхдээ хууль хүчин төгөлдөр болсон цагаас эхлэн 5 жилийн хугацааг тооцох эсэхээс хамааран мөн л иөнгөн урамшуулалд хамрагдах албан хаагчийн тоо, урамшуулалд зарцуулах мөнгөн дүн өөрчлөгдөх боломжтой байна.

Ялангуяа боловсрол, эрүүл мэндийн салбарт төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийн хүрээнд ХБХ-ий эрхийг хамгаалах асуудал ажил, мэргэжлийн хувьд өргөн хүрээг хамрах шинжтэй байгаа нь “салбарын ажилтан” гэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв /6 аймаг/-д ажиллаж буй албан хаагчдыг тооцохоос гадна аль салбарын, ямар мэргэжлийн, ямар тусламж, үйлчилгээ эрхэлж буй ажилтан, албан хаагчийг ойлгох талаар тодорхой зохицуулалт шаардлагатайг харуулж байна.

1.2.13. Хөгжлийн бэрхшээлтэй хүний болон ХБ-тэй хүүхэдтэй эцэг эхийн сургалтын төлбөрийг төр хариуцахтай холбоотой гарах зардлыг тодорхойлох нь

Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь зүйлд “Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сангаас санхүүжүүлнэ” гэж тусгажээ.

БШУСайд 2023 оны 4 дүгээс сарын 14-ний өдөр УИХ-ын Байнгын хороодын хуралдаанд хийсэн мэдээлэлдээ 2023 оны байдлаар 414 ХБХ их, дээд сургуульд суралцаж байгаа талаар мэдээлсэн. Харин ХБХ-ий боловсролын түвшний талаарх судалгаагаар 2020 оны байдлаар улсын хэмжээнд 569 магистр, 36 докторын зэрэгтэй ХБХ байна гэжээ³⁸. Харин эдгээр мэдээллээс ХБХ хүн магистр, докторын зэрэг хамгаалсан эсхүл ХБ-тэй болохоос өмнө магистр, докторын зэрэг хамгаалсан эсэхийг тогтоох боломжгүй байна. Иймээс эдгээр тоо мэдээлэлд үндэслэн хичнээн 50 хувиас дээш хөдөлмөрийн чадвараа алдсан ХБХ магистр, докторын зэрэг хамгаалах сургалтад хамрагдаж болох талаар тойм тоо гаргахыг зорьлоо. Ингэхдээ магистр, доктороор суралцах насны хязгаарыг тогтоохдоо олон улсын их дээд сургуулиудад тэтгэлэг олгох насны хязгаарыг, мөн ХБХ-ийн дунд эзлэх магистр, докторын зэрэгтэй хүний эзлэх хувь, нийт ХБХ-ий дунд 16-40 насны ХБХ-ий эзлэх хувийг тус тус тогтоох замаар тоон үзүүлэлтийг гаргахыг зорьно.

2020 оны Хүн ам, орн сууцны тооллогын тайлангаас харахад 107,075 ХБХ хүний 0,005 хувь нь буюу бакалаврын зэрэгтэй ХБ оюутны 0,05 хувь магистрын, магистрын

³⁸ СТАТИСТИК: Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй 15-аас дээш насны иргэдийн 31.6 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Эх сурвалж: <https://ikon.mn/n/2244>

зэрэгтэй ХБХ хүний 0,06 хувь нь докторын зэрэгтэй байсан байна. Насны хязгаарын хувьд ерөнхийдөө магистраар суралцах бол 35, докторт суралцах бол 40 хүртэлх насны хязгаар тавьдаг³⁹ бөгөөд ХБХ-ий тухайд насны хязгаар тогтоохгүй байх талаар мэдээлэл байхгүй. Иймээс 2010 онд ҮСХ-ноос гаргасан судалгааны⁴⁰ дүнгээс харахад нийт ХБХ хүний 0,25 хувь нь 25-40 насны ангилалд багтаж байжээ.

2022 оны байдлаар Монгол Улсад 115,115 ХБХ хүн байгаагаас 1150 гаруй хүн бакалаврын сургалтад хамрагдах магадлалтай бол магистр, доктороор суралцах насны буюу 25-40 насны 28,778 иргэн байх боломжтой байна. Дээр дурдсанчлан ХБХ бакалаврын зэрэгтэй оюутны 0,05 хувь магистрт суралцсан өмнөх жишгээр тооцвол 57 ХБХ, докторт суралцагчийн тоо 3,4 байх таамаглал дэвшүүлж болох байна.

Гэхдээ эдгээр тоо нь өмнө дурдсанаар ХБ-тэй болохоос өмнө болон 50 хувиас доош хөдөлмөрийн чадвар алдсан ХБХ-ий тоог агуулсан байх тул 3 хүн тутмын нэг нь 50 хувиас дээш хөдөлмөрийн чадвараа алдсан гэх таамаг дэвшүүлэв.

Хүний нөөцийн нийт хэрэгцээг тодорхойлох нь

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр тусгагдсан зохицуулалтууд нь ХБХ-ий асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудад хэдий хэр ачаалал буюу хүний нөөцийн хэрэгцээ буюу ачаалал үүсгэхийг дараах асуудлуудын хүрээнд тоймлон тооцов. Үүнд:

1. Хөтөлбөр, аргачлал, журам, жишиг үнэ, жагсаалт батлахтай холбоотой
2. Мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах болон гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой
3. Сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахтай холбоотой
4. Үндэсний зөвлөл байгуулахтай холбоотой
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сан байгуулахтай холбоотой
6. Хувийн туслахаар хангахтай холбоотой
7. Брайль бичгээр боловсрол эзэмших, мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой
8. Халаалт, түлшний мөнгөн тусламж үзүүлэх насны хязгаарыг 18 болгон нэмэгдүүлсэнтэй холбоотой
9. Бүрэн хараагүй хүн орон нутгаас нийслэлд ирж шинжилгээ хийлгэхтэй холбоотой
10. 500 км-ээс дээш зайд алслагдсан нутгаас нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэхтэй холбоотой
11. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбоотой
12. ХБХ-ий орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах нэг удаагийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хийгдэх стандарт үйл ажиллагаанууд төрд буюу төрийн байгууллагуудад үүсгэх хүний нөөцийн ачааллыг доорх хүснэгтэд харуулснаар тодорхойлсон.

³⁹ Боловсролын мэдээллийн сан. Эх сурвалж:

<https://scholarship.esis.edu.mn/grant/news%20more.html?more=38>

⁴⁰ https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Hugjliin_berhsheel_MGL.pdf&ln=Mn

Нэгж	Ажил үйлчилгээ/ Хуулийн заалт	Хүний нөөцийн хэрэгцээ
Засгийн газар	Хуулийн төслийн 22.4, 23.5, 37.2	0,3
Нийт хүний нөөцийн хэрэгцээ		0,3
ХБХ-ий асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн	Хуулийн төслийн 7.1.1, 20.3, 21.3.2, 24.5, 28.1, 28.3, 28.4, 28.7, 37, 42.2	0,42
Нийт хүний нөөцийн хэрэгцээ		0,42
Боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн	Хуулийн төслийн 9.2, 10.2, 11.4, 24.5, 17.1.5, 32.5	0,18
Нийт хүний нөөцийн хэрэгцээ		0,18
Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн	Хуулийн төслийн 26.7	0,6
Нийт хүний нөөцийн хэрэгцээ		0,06
ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага	Хуулийн төслийн 13.1	0,07
	Хуулийн төслийн 37.2	0,18
	Хуулийн төслийн 33	4,6
Нийт хүний нөөцийн хэрэгцээ		4,85
Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Хуулийн төслийн 10.1.5, 10.1.8, 11.4	0,14
Нийт хүний нөөцийн хэрэгцээ		0,14
Төрийн өмчийн сургалтын байгууллага	Хуулийн төслийн 9.1	0,004
Нийт хүний нөөцийн хэрэгцээ		0,024
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	Хуулийн төслийн 22.1.1.	2,4
	Хуулийн төслийн 22.1.9, 22.1.10	38,5
	Хуулийн төслийн 21.5	12,4
Нийт хүний нөөцийн хэрэгцээ		40,9

Үүнээс үзэхэд хуулийн төсөлд шинээр нэмэгдсэн зохицуулалтуудаар хүлээлгэсэн үүрэг буюу хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад Засгийн газарт 0,3 хүн, ХБХ-ий асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд 0,42, Боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд 0,18, ХЗДХ-ийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд 0,06, ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад 4,85, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад 0,14, төрийн өмчийн сургалтын байгууллагад 0,004, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт 40,9 хүний нөөцийг шинээр бий болгох шаардлагатай байна.

Аливаа үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ 1 бүхлээс доош байгаа тохиолдолд тухайн үүргийг дотоод зохион байгуулалт, ажил үүргийн хуваарьт

өөрчлөлт оруулах замаар хүний нөөцийн ачаалал шинээр үүсгэхгүйгээр зохицуулах боломжтой гэж үздэг.

Иймээс хүний нөөцийн хэрэгцээ, түүнээс үүдэх зардлыг ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын тухайд тооцож үзэх шаардлагатай.

1.3.Гарах зардлыг урьдчилан тооцох

Төрийн захиргааны байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал /төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал/
- Материаллаг зардал /төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал/
- Бусад зардал /тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал/-ыг тооцож гаргана.

А.Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн цалингийн хэмжээг ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”⁴¹-ээр, төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээг мөн тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын цалингийн доод хэмжээ”⁴²-нд үндэслэн цалинжихаар дундаж цалингийн хэмжээг тооцоолов.

Эхний ээлжинд ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын албан хаагчид зарцуулах зардлыг тооцно. Ингэхдээ төрийн захиргааны албан хаагчийн цалингийн дундаж хэмжээ болох **1.702.800** төгрөгийн дундаж цалинг суурь үзүүлэлт болгон ашиглана.

⁴¹ ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт. Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ. Эх сурвалж: [Эрх зүйн акт дэлгэрэнгүй \(legalinfo.mn\)](http://legalinfo.mn)

⁴² ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт. Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын цалингийн доод хэмжээ [Эрх зүйн акт дэлгэрэнгүй \(legalinfo.mn\)](http://legalinfo.mn)

Албан тушаалын зэрэглэл	1	2	3	4	5	6	7
ТЗ	2,440,000	2,171,000	2,048,000	1,933,000	1,757,000	1,597,000	1,452,000
ТҮ	1,000,000	1,100,000	1,210,000	1,271,000	1,334,000	1,400,000	1,471,000
	8	9	10	11	12	Дундаж цалин	
ТЗ	1,320,000	1,210,000	1,100,000			1,702,800	
ТҮ	1,544,000	1,621,000	1,703,000			1,365,400	

Хуулийн төсөлд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шинээр бий болгох шаардлагатай хүний нөөцийн зардлыг тооцоходоо нэг албан хаагчийн зардлыг түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ ажилласан жилийн нэмэгдэл, 4/ зэрэг дэвийн нэмэгдэл, 5/ буцалтгүй тусламж, 6/ шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг. Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 30%-иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцох боломжтой юм.

Хүснэгт № Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал

Албан тушаалын зэрэглэл	Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
ТЗ	Үндсэн цалингийн дундаж хэмжээ	1,702,800		1,702,800
	Нийтлэг зардал	1,702,800	15%	255,420
	Дагалдах зардал	1,702,800	10%	170,280
	Нэмэгдэл, урамшууллын зардал	1,702,800	30%	510,840
	Нийт			2,639,340
ТҮ	Үндсэн цалингийн дундаж хэмжээ	1,365,400		1,365,400
	Нийтлэг зардал	1,365,400	15%	240,750
	Дагалдах зардал	1,365,400	10%	136,500
	Нэмэгдэл, урамшууллын зардал	1,365,400	30%	409,500
	Нийт			2,151,750

Хүний нөөцийн зардал үүсэх төрийн байгууллага	Шаардлагатай орон тоо	Цалингийн зэрэглэл	Цалингийн зардлын хэмжээ/ 1 сар	Цалингийн зардлын хэмжээ/ 12 сар
ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын албан хаагч	4,85	ТЗ	10,435,987,5	125,231,850

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын албан хаагч	40,9	ТҮ	88,006,575	1,056,078,900
Нийт				1,181,310,750

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр тусгасан, өөрчлөлт оруулсан зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийн нэг жилийн цалингийн нийт зардал нь **1,181,310,750** /Нэг тэрбум нэг зуун наян нэгэн сая гурван зуун арван мянга долоон зуун тавь/ төгрөг болно.

Б.Материаллаг зардал

Материаллаг зардалд тухайн үүргийг гүйцэтгэж буй нэг албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг ойлгоно. Тухайлбал албан хаагчийн ажлын байр, өрөө тасалгаа, техник хэрэгсэл, шаардлагатай бусад зардлыг энд тооцох хэрэгтэй.

ХБХ-ий асуудал эрхэлсэн байгууллага нь ХБХ-нд нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргээ нийсэлийн 9 дүүрэг, 152 хороо, 21 аймаг, 330 сум болон гадаад улс дахь 77 дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан хэрэгжүүлдэг тул дээрх зардлуудын дийлэнхийг, тухайлбал урсгал зардлыг /халаалт, цэвэр, бохир ус, цахилгаан, урсгал засвар гэх зэрэг/ үйлчилгээний байр тус бүрээр ерөнхий байдлаар гаргадаг тул ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, мөн хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 1 албан хаагчид зарцуулах материаллаг зардлыг нарийвчлан тооцож гаргах боломжгүй байна. Иймд “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-д жишээ болгон авсан ХЗДХЯ-ны нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав.

Хүснэгт № Нэг албан хаагчид гарах материаллаг зардал

Зардлын нэр	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000
	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Нийт	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал засвар	127,752
	Газрын төлбөр	22,253
	Нийт	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж ⁴³	160,000

⁴³ нэг албан хаагчид хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн үнийг дунджаар 800,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл хорогдлын хэмжээг зг-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох журам, үндсэн хөрөнгийн дэдэгдэл, хорогдлыг тооцоход баримтлах хугацаа”-нд тусгаснаар 20% -иар тооцов.

	Тавилга, эд хогшил ⁴⁴	100,000
	Барилга, байгууламж	65,670
	Нийт	325,670

Дээр тооцсон бүх зардал нийтдээ нэг албан хаагчийн “ажлын байрны дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлэх юм.

Ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал
=
Урсгал зардал + Барилга, байгууламж, өрөө тасалгааны тооцоот зардал + Элэгдэл хорогдолын зардал

Хүснэгт № Ажлын байртай холбоотой үүсэх дундаж материаллаг зардал

Материаллаг зардал	Зардлын хэмжээ /төгрөг
Урсгал зардал	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал	325,670
Нийт	1,952,317

Дээрх томъёог ашиглан төрд үүсэх материаллаг зардлыг тооцвол ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, мөн хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 1 албан хаагчид зарцуулах материаллаг зардлын хэмжээ дунджаар **1,952,317** /нэг сая есөн зуун тавин хоёр гурван зуун арван долоо/ төгрөг бол .

Хүний нөөцийн зардал үүсэх төрийн байгууллага	Шаардлагатай орон тоо	Материаллаг зардал/1хүн	материаллаг зардлын хэмжээ
ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын албан хаагч	4,85	1,952,317	9,468,737
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын албан хаагч	40,9	1,952,317	79,849,765
нийт	45,75	-	89,318,502

ХБХ-ий эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн байгууллагад буюу төрд үүсэх хүний нөөцийн зардал болох цалингийн зардал болон материаллаг зардлыг тооцож үзвэл цалингийн болон материаллаг зардлын хэмжээ нэг жилд 755,955,533 төгрөг гарахаар байна.

Хүний нөөцийн зардал	Цалингийн зардал	Материаллаг зардал	нийт
----------------------	------------------	--------------------	------

⁴⁴ тавилга, эд хогшлын үнийг дунджаар 1,000,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл, хорогдлыг зг-ын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгаснаар 10%-иар тооцов.

ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын албан хаагч	125,231,850	9,468,737	134,700,587
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын албан хаагч	1,056,078,900	79,849,765	1,135,928,665
Нийт	1,181,310,750	89,318,502	1,270,629,252

В.Бусад зардал

Бусад зардал гэдэгт төрийн байгууллагаас үүрэг биелүүлэхэд буюу ямар нэгэн ажил үйлчилгээ гүйцэтгэхэд гарах зардлыг биш, харин тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал хамаардаг.

ХБХ-ий эрхийг хангах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд жил бүр “бусад зардал” үүсгэх дараах зохицуулалтууд байна гэж үзлээ. Үүнд

Хуулийн төслийн зүйл, заалт	Үйл ажиллагааны нэр	Үүрэг хүлээх байгууллагын тоо	Үүсэх зардал/нэг байгууллагад	Үүсэх зардал/нийт байгууллагад
Хуулийн төслийн 28.2.1	“Хувийн туслах” үйлчилгээ	2456	5,631,848	13,831,818,000⁴⁵
Хуулийн төслийн 12.1	Брайль бичгээр мэдээлэл хүргэх, нийгмийн харилцаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэх	7426 ⁴⁶	8000	59,408,000
Хуулийн төслийн 22.1.1	18 нас хүртэлх ХБХүүхдэд халаалт, түлшний зардал олгох	1534	140,000	214,760,000
Хуулийн төслийн 22.1.5, 22.1.9	500-аас дээш км-т алслагдсан аймаг, суманд байнга оршин суугаа ХБХ-д замын зардал олгох	2714	50,564	137,230,696⁴⁷

⁴⁵ Хуулийн төслийн 28.2.1-т заасан “Хувийн туслах” үйлчилгээг хэрэгжүүлэхэд 1,617,000 төгрөг * 8554 суралцагч = 13,831,818,000 төгрөгийн зардал үүсгэнэ. Энэ нь улсын хэмээнд үйл ажиллагаа явуулж буй 2456 төрийн болон хувийн өмчийн сургалтын байгууллагад 3-4 ХБХ суралцаж байна гэж үзвэл нэг сургалтын байгууллагад дунджаар 5,631,848 төгрөгийн зардал үүсэхээр байна

⁴⁶ 4740 улсын төсвийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, 393 төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар⁴⁶ болон өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 1454 СӨБ-ын байгууллага, 839 ЕБС-иар тооцон нийт 7426 байгууллагад хамаарна гэж үзсэн

⁴⁷ Хуулийн төслийн 22.1.5, 22.1.9-г заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд нийслэлээс 500-аас дээш км-т алслагдсан аймаг, суманд байнга оршин суугаа 24,671 ХБХ-ий 11% буюу хамгийн багадаа 2714 хүнд эмчилгээ, шинжилгээнд хамрагдахаар нийслэлд ирэх, буцах зардлын дундаж хэмжээ болох 50,564 төгрөгийг олгох шаардлага үүснэ гэж үзсэн ба үүний санхүүжилтийн хэмжээ 137,230,696 төгрөг байна.

Хуулийн төслийн 20.2.4	ХБХ-ий оршин суугаа орон байрны тохируулга, хүртээмжийг сайжруулах зорилгоор олгох нэг удаагийн тусламж	нийслэл болон 21 аймаг		1,592,535,000⁴⁸
НИЙТ				42,676,366,696

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр бий болсон болон өөрчлөлт орсон зохицуулалтууд нь төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хамаарах албан хаагчдын заавал эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадварт суурилсан, мөн эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шинээр ажил үйлчилгээ худалдан авах шаардлагагүй гэж үзсэн тул бусад зардал гаргахгүй. Харин хуулийн төслийн 28.2.1, 12.1, 22.1.1, 22.1.5, 22.1.9, 20.2.4 дахь заалтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай зардлын хэмжээ **42,676,366,696** төгрөг байна.

1.4.Зардлыг нэгтгэн тооцож гаргах

Энэ үе шатанд төрийн захиргааны байгууллагаас буюу төрд нэг жилд үүсэх нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ хүний нөөцийн зардал, материаллаг зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцох ба үүн дээр бусад зардлыг нэмснээр нийт зардлын хэмжээ гарах юм.

Зардлын төрөл	Зардлын хэмжээ/ 1 сард	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал/1 жилд
Хүний нөөцийн зардал	1,365,400	40,9	1,181,310,750
Материаллаг зардал ⁴⁹	1,952,317	51,7	89,318,502
Бусад зардал	0	0	42,676,366,696
Нийт			43,946,995,948

Дээрх хүснэгтээс харахад “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д шинээр нэмсэн болон өөрчлөлт орсон зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудад буюу төрд **43,946,995,948** төгрөгийн ачаалал үүсэхээр байна.

⁴⁸ Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтын хэрэгжилтийг хангахын тулд шинээр баригдсан орон сууцны 2%-ийг худалдан авах зардлыг жил бүр төсөвт эсхүл тодорхой санд байршуулах боломжтой орон сууцны зай талбайг дунджаар 45 м2 гэж, 1 м2 талбайн үнийг 2019 оны жишгээр 1,350,000 төгрөг байхаар тооцож үзэхэд нэг жилд улсын хэмжээнд буюу нийслэл болон 21 аймгийн хэмжээнд хамгийн багадаа 28,433,150,000 төгрөгийн хуримтлал үүсгэх шаардлага үүсгэж байна.

⁴⁹ 1 удаа олгохоор тооцов.

1.5.Хувилбарыг нягтлах, үр дүнг танилцуулах

Ийнхүү зардлын тооцоо хийхийн гол зорилго хуулийн төслийн хүрээнд төрийн захиргааны байгууллагад шинээр бий болж байгаа үүргээс үүдэлтэй ачааллыг хөнгөвчлөхөд оршино. Иймд эрх зүйн тухайн зохицуулалт буюу бэлтгэж буй төсөлд төрд үүсэх зардлыг хэмнэх боломж бий эсэхийг гэдгийг шалгаж үзэх нь чухал байдаг. Хуулийн төслийн зардлын тооцооны үр дүнд хуулийн төслийн холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлснээр үүсэх зардлыг багасгах чиглэлээр анхаарч болох дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Алслагдсан аймаг, сумдад байнга оршин суудаг ХБХ болон бүрэн хараагүй хүний нийслэлд ирж эмчилгээ хийлгэх, шинжилгээ өгөх болон буцах замын зардлыг нөхөн олгохтой холбоотой гарах замын зардлыг олгох асуудлын хүрээнд “дээрх эмчилгээ, шинжилгээнд хамрагдах зайлшгүй шаардлагатай хүн”-ий тоог нарийвчлан гаргаснаар зардлын хэмжээг бууруулах боломжтой. Үүнээс гадна бүсийн эмчилгээ, оношлогооны төвүүдийн хүчин чадал, тоног төхөөрөмжийг шинэчлэх, эмч, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх замаар ХБХ өөрт ойр эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэснээр улсын төсвөөс жил бүр гарах зардлыг хэмнэх, ХБХ-ээс гадна алслагдсан орон нутгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар дээшлэх давхар ач холбогдолтой байна.
2. ХБХ-ий эрхийг хамгаалах салбарын ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, нөхөх олговор, шагнал урамшуулал авах, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг хамгаалах, өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж, цол авах, хөнгөлөлт, урамшуулалд хамрагдах, орон сууц барих эсхүл худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл, тусламжид хамрагдах зэрэг эрхийг шинээр тусгаж өгсөн. Гэвч “ХБХ-ий эрхийг хамгаалах салбарын ажилтан” гэж аль салбарын, ямар мэргэжлийн, ямар тусламж, үйлчилгээ эрхэлж буй ажилтан, албан хаагчийг ойлгох нь тодорхойгүй байгаа тул энэ хуулиар нийгмийн баталгааг нь хангах шаардлагатай салбар, байгууллага, ажил мэргэжил зэргийг тодорхойлох шаардлагатай гэж үзлээ.
3. ХБХ-ий бүртгэл, мэдээлэл, судалгааг оршин суугаа байршил, өвчний төрөл, зэрэглэл зэрэг олон талт байдлаар нарийвчлан хөтлөх нь цаашид ХБХ-ий хэрэгцээ шаардлагад нийцсэн, тэдний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн аливаа төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа гаргах зэрэг үйл ажиллагааг бодитой, хүртээмжтэй төлөвлөхөд сайн нөлөө үзүүлэхээр байгааг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦОХ НЬ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу алхам тус бүрийн хүрээнд мэдээлэл цуглуулан, стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэн дараах тооцооллыг хийлээ.

Зардлын тооцоог дараах алхмын хүрээнд хийнэ. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох
2. Зардал тооцох
3. Тоон үзүүлэлтийг тооцох
4. Зардлын дүнг тооцож гаргах
5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах
6. Нэмэлт зардал тооцох

2.1.Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

ХБХ-ий эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд хуулийн этгээдэд үүрэг нэмж хүлээлгэсэн шинээр нэмэгдсэн болон өөрчлөн найруулсан зохицуулалтуудаас үүсэх зардлын тооцооллыг энэ бүлэгт гаргана.

ХБХ-ий эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр нэмэгдсэнээр хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн дараах зохицуулалт байна. Ү

№	Хуулийн зохицуулалт	Үүрэг
1.	7.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, тэдний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлийн ойлголт хандлага нэмэгдүүлэх сургалтад 3 жил тутамд хамрагдана	3 жил тутамд сургалтад хамрагдах
2.	7.1.2. өмчийн бүх хэлбэрийн байгууллага, иргэн нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалт, сурталчилгааг зохион байгуулна.	Сургалт тогтмол зохион байгуулах
3.	11.3. Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь сонсголтгүй хүний дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхийг хангана.	Дохионы хэлээр харилцах боломж бүрдүүлэх
4.	12.1. Харааны бэрхшээлтэй хүн брайль бичгийг ашиглан боловсрол эзэмших эрхтэй бөгөөд бүх түвшний боловсролын сургалтын байгууллага харааны бэрхшээлтэй хүн брайль бичиг болон бусад технологи ашиглан боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.	Брайль бичгээр мэдээлэл хүргэх
5.	23.4.Шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл хууль хяналтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй	Өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлэхээс гадна текст

	хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангана.	уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах
6.	40.1.8.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчих, ялгаварлах, бэлгийн дарамт үзүүлэхийг үл тэвчих асуудлыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх;	Журам боловсруулах/өөрчлөлт оруулах

2.2.Зардал тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана. Хуулийн этгээдийн зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг⁵⁰ тодорхойлж, тус бүрт зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

Зардлыг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох
2. Тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох
3. Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэсэн бөгөөд цаг хугацааг тооцохдоо зарцуулах хугацааг минутаар тооцож гаргалаа.

Ажлын хөлсийг тооцох

Ажлын хөлсийг тогтоохдоо аж ахуйн нэгжид ажиллаж буй ажилтны сарын дундаж цалин хөлсний улсын дундаж хэмжээг сүүлийн 3 жилээр баримжаалан тооцов. Мөн нэг сард ажиллах хугацааг тооцож гарган үндсэн цалинг ажилах хугацаанд хувааснаар тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг тооцож гаргана.

Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин⁵¹

Он	2018 онд	2019 онд	2020 онд	Дундаж дүн
Улсын дундаж цалин	1,002,900	1,124,300	1,220,600	1,115,933

⁵⁰ Үүрэг тус бүрийн гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг стандарт үйл ажиллагаа гэнэ. Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загварыг ЗГ-ын 2006 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын Хүснэгт 1-ээс үзэх боломжтой.

⁵¹ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, бүс, аймаг, нийслэл, хүйс, улирал, жилээр. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Эх сурвалж: http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0400_022V1&Salbar_select_all=0&SalbarSingleSelect=1&Gender_select_all=0&GenderSingleSelect=1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=2020_2019_2018&viewtype=table Сүүлд нэвтэрсэн 2021.09.25

Аж ахуй нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол өссөн үзүүлэлтэй байна. Сүүлийн гурван жилийн дундаж цалинд үндэслэн ажилтны нэг сарын ажлын хөлсийг **1,115,933** байхаар, ажиллах хугацааг хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид заасан ажлын хоног, ажиллах цагт үндэслэлээ.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байхаар зохицуулсан байдаг. Үүнээс харахад нэг ажилтан нэг сард ажлын 22 өдөр ажилладаг гэж үзлээ.

Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны ажлын хөлсийг цаг, минутаар

Үндсэн цалин	/	Ажиллах хугацаа	=	Ажлын хөлс /төгрөг/
1,115,933	/	176 цаг	=	6,340⁵² төг /цагт/
1,115,933	/	10560 минут	=	105⁵³ төг /минут/

ХБХ-ий эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр нэмэгдсэн, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн зардал тооцох боломжтой зохицуулалтуудыг өмнөх хэсэгт хүснэгтээр харуулсан. Эдгээр зохицуулалтыг агуулгаар нь ангилж үзвэл

- Сургалтад хамрагдах /3 жил тутамд/
- Сургалт зохион байгуулах /тогтмол/
- Хувийн туслахаар хангах /сургалтын байгууллага/
- Дохионы хэлээр харилцах боломж бүрдүүлэх
- Брайль бичгээр мэдээлэл хүргэх
- Өмгөөллийн үйлчилгээг төлбөргүй үзүүлэх, текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах
- Журамд өөрчлөлт оруулах

Иймд зардал тооцох энэ хэсэгт дээр дурдсан үйл ажиллагаа нэг бүрийг хэрэгжүүлэх ажилтны ажлын хөлсийг жишиг хэлбэрээр тооцох болно.

Үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа (мин)	Ажлын хөлс (төг)	Зардал (төг)
Сургалтад хамрагдах	Сургалтын талаар мэдээлэл цуглуулах	15	105	1575
	Албан бичиг боловсруулах	10	105	1050
	Маягт бөглөх	7	105	735
	Дотоод хуралдаан хийх	30	105	3150
	Мөнгө шилжүүлэх	8	105	840
Нийт		70	525	7350
	Сургалтын талаар мэдээлэл цуглуулах	15	105	1575
	Мэдээлэл цуглуулах	768	105	80640

⁵² Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны 1 цагийн ажлын хөлс 5587,5 төгрөг байгаа бөгөөд энэ тохиолдолд 5587 төгрөг болгон тэгшитгэсэн болно.

⁵³ Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны 1 минутын ажлын хөлс 93,125 төгрөг байгаа бөгөөд энэ тохиолдолд 93 төгрөг болгон тэгшитгэсэн болно.

Сургалт зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр боловсруулах, батлах	1440	105	151200
	Сургалт зохион байгуулах	480	105	50400
	Олшруулах, архивлах, тараах	15	105	1575
Нийт		2718	525	285390
Хувийн туслахаар хангах /сургалтын байгууллага	Материал хүлээж авах	2	105	210
	Мэдээллийг хянах, шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хянах	10	105	1050
	Бүртгэлийн баримт олгох	3	105	315
	Бүртгэлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх	60	105	6300
	Хуулбарлах	3	105	315
	Цахим санд оруулах	10	105	1050
Нийт		88	630	9240
Дохионы хэлмэрч оролцуулах	Үүрэгтэй танилцах	3	105	315
	Мэдээлэл цуглуулах	15	105	1575
	Дохионы хэлмэрч захиалах, гэрээ байгуулах	120	105	12600
	Мөнгө шилжүүлэх	8	105	840
Нийт		146	420	15330
Брайль бичгээр мэдээлэл хүргэх	Үүрэгтэй танилцах	15	105	1575
	Мэдээлэл боловсруулах	480	105	50400
	Мэдээллийг нягтлах, алдааг засах	15	105	1575
	Мэдээллийг хэвлүүлэх захиалга өгөх	20	105	2100
	Мэдээллийг хэвлэлтэд шилжүүлэх	5	105	525
	Хэвлэсэн материалыг хүлээн авах	30	105	3150
	Мэдээллийг байршуулах	5	105	525
Нийт		570	735	59850
Өмгөөллийн үйлчилгээг төлбөргүй үзүүлэх, текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах	Үүрэгтэй танилцах	15	105	1575
	Мэдээлэл цуглуулах	120	105	12600
	Бусадтай хуралдах/зөвлөлдөх	480	105	50400
	Дотоод хуралдаан хийх	30	105	3150
	Мэдээлэл шилжүүлэх	5	105	525
	Тоо баримт, баримт бичиг боловсруулах	120	105	12600
	Олшруулах, архивлах, тараах	15	105	1575
Нийт		785	735	82425
Журамд өөрчлөлт оруулах	Үүрэгтэй танилцах	3	105	315
	Мэдээлэл цуглуулах	15	105	1575
	Баримт бичиг боловсруулах	120	105	12600
	Дотоод хуралдаан хийх	30	105	3150
	Олшруулах, архивлах, тараах	15	105	1575
Нийт		183	525	19215

2.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үржүүлнэ.

Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо)
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо)

Тохиолдлын тоо: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр тусгасан зохицуулалтын улмаас үүрэг хүлээх хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, бүх шатны сургалтын байгууллага, өмгөөллийн нөхөрлөл зэрэг байна. Хуулийн этгээдэд хамаарах тохиолдлын тоог тодорхойлохдоо дараах нөхцөлийг харгалзан үзсэн болно. Үүнд:

1. ХБХ-д үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн тоог тодорхойлох шалгуур тогтоогоогүй тул энэ тооцоололд 25-аас дээш хүн ажиллуулдаг хуулийн этгээдийн тоог жишиг болгон тохиолдын тоогоор сонголоо. Үндсэндээ аливаа худалдаа, үйлчилгээ эрхлэх хувь хүн, хуулийн этгээд бүр ХБХ-нд үйлчлэх шаардлага үүсэх магадлалтайг тул сонгосон тохиолдлын тоо өсөх боломжтой юм.
2. Бүх шатны сургалтын байгууллагын тохиолдлын тоог статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь хувийн хэвшлийн сургалтын байгууллагын тоогоор тооцсон бөгөөд үүнд СӨБ-ын байгууллага болон ЕБС багтаагүй болно.
3. Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэх тохиолдлын тоог улсын хэмжээнд үйл ажтллагаа явуулж буй өмгөөллийн нөхөрлөлийн тоогоор⁵⁴ байхаар тогтоолоо.

Тохиолдлын тоог тогтоохдоо хуулиар үүрэг хүлээж байгаа хуулийн этгээдийн том, жижгийг харгалзаж үзэх шаардлагатай. Хэрэв тухайн зохицуулалт хуулийн этгээдийн хэд хэдэн үйл ажиллагааны төрлийг хамарч байвал тэдгээрийг тухай бүр харгалзан үзэж зардлыг гаргах шаардлагатай⁵⁵ байдаг.

Давтамжийн тоо: Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн зохицуулалтуудыг хэрэгжүүлэх давтамжийн тоо харилцан адилгүй тул үүрэг тус бүрт өөр өөр байна. Тухайлбал,

- 3 жил тутамд сургалтад хамрагдах үүргийн давтамж 0,33
- Тогтмол сургалт зохион байгуулах үүргийн давтамжийг 2 /6 сард 1 байхаар/

⁵⁴ ХБХЭТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлангийн ХБХ-ий хууль зүйн туслалцаа авах эрх хэсэгт дурдсан 2017 онд 121 иргэний байцаан шийтгэх ажиллагаанд дохионы хэлмэрч оролцсон гэх мэдээллийг ашиглав. Шүүхийн болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, мэдээнд хичнээн ХБХ сэжигтэн, яллагдагчаар татагдсан болон хохирогч болсон талаар мэдээлэл байхгүй нь энэ төрлийн статистик мэдээ хөтөлдөггүйг харуулж байна.

⁵⁵ Хууль тогтоомжийн тухай хууль аргачлал, гарын авлага. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах” төсөл. Улаанбаатар хот. 2016 он.

- Хувийн туслахаар хангах үүргийн давтамжийг 10,6⁵⁶ байхаар
- Брайль бичгээр мэдээлэл хүргэх үүргийн давтамжийг 2 /хагас жилд 1 байхаар/
- Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх үүргийн давтамжийг 1 байхаар
- Журамд өөрчлөлт оруулах үүргийн давтамжийг 0,2 /5 жилд 1 удаа өөрчлөхөөр/ тус тус тооцов.

Үүрэг	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
7.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, тэдний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлийн ойлголт хандлага нэмэгдүүлэх сургалтад 3 жил тутамд хамрагдана	4313	0,33	1,423
7.1.2. өмчийн бүх хэлбэрийн байгууллага, иргэн нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалт, сурталчилгааг зохион байгуулна.	4313	2	8,626
11.3. Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь сонсголгүй хүний дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхийг хангана.	97 ⁵⁷	10,6	1,028
12.1. Харааны бэрхшээлтэй хүн брайль бичгийг ашиглан боловсрол эзэмших эрхтэй бөгөөд бүх түвшний боловсролын сургалтын байгууллага харааны бэрхшээлтэй хүн брайль бичиг болон бусад технологи ашиглан боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.	4313	1	4,313
23.4.Шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл хууль хяналтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангана.	4313	2	8,626
40.1.8.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчих, ялгаварлах, бэлгийн дарамт үзүүлэхийг үл тэвчих асуудлыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх;	220 ⁵⁸	1	220
7.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, тэдний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлийн ойлголт хандлага нэмэгдүүлэх сургалтад 3 жил тутамд хамрагдана	4313	0,2	8,6

⁵⁶ Улсын хэмжээнд төрийн болон хувийн 166 ТМС, дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр сургуульд суралцах оюутнуудын 7,7% буюу 1770 оюутан ХБ-тэй байна гэж судалгааны 1 дэх хэсэг тооцсоныг жишиг болгов. Энэ нь 1 мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагад 10,6 ХБ-тэй оюутан ногдох боломжтойг харуулж байна.

⁵⁷ Хувийн хэвшлийн Техникийн болон мэргэжлийн боловсролын сургууль 29, Дээд боловсролын сургалтын байгууллага 65, Олон нийтийн/шашны өмчийн 3 сургуулиар тооцон тохиолдлын тоог тогтоов.

⁵⁸ Статистикийн мэдээллийн сан дахь мэдээллээр 2020 оны эцэст 220 өмгөөллийн нөхөрлөл бүртгэгдсэн байна. Эх сурвалж:

https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2300_037V7&CR008_select_all=0&CR008SingleSelect=_5&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table Сүүлд нэвтэрсэн.2021.09.25

2.4.Зардлын дүнг тооцож гаргах

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргалаа.

Үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зардал (төг)	Тоон үзүүлэлт	Нийт зардал
7.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, тэдний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлийн ойлголт хандлага нэмэгдүүлэх сургалтад 3 жил тутамд хамрагдана	Сургалтад хамрагдах	7,350	1,423	10,459,050
7.1.2. өмчийн бүх хэлбэрийн байгууллага, иргэн нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалт, сурталчилгааг зохион байгуулна.	Сургалт, сурталчилгаа зохион байгуулах	285,390	8,626	2,461,774,140
11.3. Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь сонсголгүй хүний дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхийг хангана.	Хувийн туслахаар хангах /сургалтын байгууллага	9240	1,028	9,498,720
12.1. Харааны бэрхшээлтэй хүн брайль бичгийг ашиглан боловсрол эзэмших эрхтэй бөгөөд бүх түвшний боловсролын сургалтын байгууллага харааны бэрхшээлтэй хүн брайль бичиг болон бусад технологи ашиглан боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.	Дохионы хэлмэрч оролцуулах	15330	4,313	66,118,290
23.4.Шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл хууль хяналтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангана.	Брайль бичгээр мэдээлэл хүргэх	59850	8,626	516,266,100
40.1.8.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчих, ялгаварлах, бэлгийн дарамт үзүүлэхийг үл тэвчих асуудлыг	Өмгөөллийн үйлчилгээг төлбөргүй үзүүлэх, текст уншигч,	82425	220	18,573,500

байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх;	бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах			
7.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, тэдний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлийн ойлголт хандлага нэмэгдүүлэх сургалтад 3 жил тутамд хамрагдана	Журамд өөрчлөлт оруулах	19215	8,6	165,249
Нийт зардал				3,082,855,049

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр нэмэгдсэн, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн агуулга бүхий зохицуулалтууд нь үүрэг хүлээж буй нийт хуулийн этгээдүүдэд **3,082,855,049** төгрөгийн зардал үүсгэх урьдчилсан тооцоололд хүргэсэн. Эдгээр зохицуулалтууд нь хуулийн этгээдийн үйл ажилланааны цар хүрээ, үйлчилгээний төрлөөс хамааран нэг хуулийн этгээдэд үүсэх зардал харилцан адилгүй байна.

2.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардал тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн салбарт үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа. Ингэхдээ мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх, хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх, мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх, мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх, мэдээллийг бусад эх сурвалжаас авах боломжтой эсэх зэрэг шалгуурыг удирдлага болгон шалгаж дараах үр дүнд хүрэв.

1. Бүх шатны боловсролын байгууллага ХБХ-ийг хувийн туслахаар хангах тухай эрх зүйн зохицуулалт нь нэг талдаа ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангахад чухал нөлөө үзүүлэхүйц зохицуулаль болсон боловч нөгөө талдаа сургалтын байгууллагад санхүүгийн дарамт учруулж байгаа тул тухайн боловсролын байгууллагын хандлагаас хамааран ХБХ-ийг сургахгүй байх сөрөг нөлөө үзүүлж болохоор байна. Иймээс сургалтын байгууллагад хувийн туслахаар хангах асуудлаар ямар дэмжлэг үзүүлэх, ямар ХБХ-д хувийн туслах зайлшгүй шаардлагатай гэж үзэх зэрэг асуудлыг илүү тодотгож өгснөөр энэ зохицуулалтын хүрээнд үүрэг хүлээх байгууллагаас гарах зардлыг багасгах боломжтой юм.
2. Дохионы хэлмэрчийн тусламжтайгаар нийгмийн харилцаанд оролцуулах зохицуулалтын хүрээнд хуулийн этгээдэд үүсэх зардлыг багасгах тухайд дохионы хэлмэрч зайлшгүй

биечлэн байх шаардлагатайгаас бусад тохиолдолд цахимаар буюу зайнаас оролцох нөхцөлийг бүрдүүлэх нь хуулийн этгээдэд үүсэх зардлыг бууруулахад нөлөөлнө. Манай улс энэ төрлийн үйлчилгээг төрийн зарим үйлчилгээг авахад нэвтрүүлж эхэлсэн байгаа тул түүнийг улам илүү хөгжүүлэх, төрийн байгууллагаас гадна хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд ашиглах боломжтой байхаар шинэчлэх нь урт хугацаандаа дохионы хэлмэрчээр дамжуулан нийгмийн харилцаанд оролцох иргэдийн эрх ашгийг нийгмийн бүхий л салбарт хангахад үр дүнтэй шийдэл байхаар байна.

3. Брайль бичиг ашиглан боловсрол эзэмших, мэдээлэл авах, нийгмийн харилцаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтын хүрээнд үүрэг хүлээх хуулийн этгээдэд үүсэх зардлыг бууруулахын тулд харааргүй иргэд зайлшгүй үйлчлүүлэх үйл ажиллагааны тодорхой салбар, чиглэлүүдийг тодорхойлох, тэдгээр салбар, чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдэд мэдээллээ брайль бичгээр байршуулах үүргийг үлдээж, бусад салбар, чиглэлийн тухайд “хувийн туслах”-ын үйлчилгээ авах боломжтийг нээлттэй үлдээх нь энэ зохицуулалтын хүрээнд үүрэг хүлээх хуулийн этгээдийн тоог багасгах, улмаар гарах зардлыг бууруулах боломжтой юм.
4. Өмгөөллийн нөхөрлөлүүдэд ХБХ-нд хүртээмжтэй орчныг бий болгохоос гадна, текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрчээр үнэ төлбөргүй хангах үүрэг хүлээлгэсэн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй байна. Учир нь цөөн тооны томоохон өмгөөллийн нөхөрлөлөөс бусад нь ажлын байраа түрээслэдэг тул хуульд заасан хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд ихээхэн зардал, хүндрэл үүсгэхээр байна. Энэ тохиолдолд ч мөн адил байгууллагын удирдлага, ажилтны хандлагаас хамааран ХБХ-ийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч зэргээр үнэ төлбөргүй хангаж үйлчилгээ үзүүлэх асуудлын эерэг, сөрөг үр дагавар илрэнэ. Тиймээс одоо хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлж буй тогтолцоог улам боловсронгуй болгох замаар, тухайлбал, Монголын Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн туслалцааны төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын хууль зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй үзүүлж буй нэгжүүдэд ХБХ-ий хууль зүйн туслалцаа авах нөхцөлийг бүрдүүлсэн тоног төхөөрөмж, брайль бичгийн ном, эмхтгэл, мэдээллийг байршуулах, хэлмэрч, орчуулагч /гэрээгээр/ ажиллуулах зэргээр ХБХ-нд хаана хандах, ямар үйлчилгээ авах нь ойлгомжтой, тодорхой байдлыг бий болгох замаар нэгд, өмгөөллийн нөхөрлөлүүдэд үүсэх зардлыг хэмнэх, хоёрт, ХБХ илүү чанартай, бүрэн дүүрэн мэдээлэл авах орчин бүрдэх магадлалтай байна.

2.6. Нэмэлт зардал тооцох

Нэмэлт зардал гэдэг нь хуулийн төсөлд заасан үүргийн улмаас хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал, ачааллыг тооцоолох явцад гарч болох бусад зардлыг тооцоолохыг хэлнэ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1., 7.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, заалтуудыг хэрэгжүүлэхэд сургалтын төлбөр, багшийн хөлс, хувийн туслахын цалин, дохионы хэмлэмэрчийн хөлс, брайль бичгийн хэвлэлтийн үнэ гэсэн **нэмэлт зардлууд** үүсгэхээр байна.

Үүрэг	Тохиолдлын тоо	Давтамж	Зардал	Нийт зардал
Сургалтад хамрагдах	4313	0,33	120,000	170,794,800
Сургалт, сурталчилгаа зохион байгуулах	4313	2	60,000	517,560,000
Хувийн туслахаар хангах /сургалтын байгууллага	97 ⁵⁹			
Дохионы хэлмэрч оролцуулах	4313	1	30,000 ⁶⁰	129,390,000
Брайль бичгээр мэдээлэл хүргэх	4313	2	4,000 ⁶¹	34,504,000
Өмгөөллийн үйлчилгээг төлбөргүй үзүүлэх, текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах	220 ⁶²	1	30,000	6,600,000
Нийт зардал				858,848,800

2.7. Үр дүнг танилцуулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцооллыг хуулийн төслийн 7.1.1, 7.1.2, 11.3, 12.1, 23.4, 40.1.8 хэсэг, заалтуудын хүрээнд хийсэн.

Үүрэг	Үйл ажиллагааны	Нэмэлт зардал	Нийт зардал
7.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, тэдний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлийн ойлголт хандлага нэмэгдүүлэх сургалтад 3 жил тутамд хамрагдана	10,459,050	170,794,800	181,253,850
7.1.2. өмчийн бүх хэлбэрийн байгууллага, иргэн нь ажилтан, албан хаагчдынхаа дунд	2,461,774,140	517,560,000	2,979,334,140

⁵⁹ Хувийн хэвшлийн Техникийн болон мэргэжлийн боловсролын сургууль 29, Дээд боловсролын сургалтын байгууллага 65, Олон нийтийн/шашны өмчийн 3 сургуулиар тооцон тохиолдлын тоог тогтоов.

⁶⁰ Дохионы хэлмэрч 1 удаа 30 минут дохих бөгөөд хөлс нь 30,000 төгрөг байна. 25-аас дээш ажилтантай хуулийн этгээдүүд болон өмгөөллийн нөхөрлөлүүд 1 жилд 1 удаа дохионы хэлмэрчээр үйлчлүүлнэ гэж дундаж тооцоо гаргав.

⁶¹ Брайль бичгээр 1 нүүр материал хэвлэх зардал 400 төгрөг, 1 хуулийн этгээд дунджаар 10 нүүр мэдээлэл хэвлүүлнэ гэж тооцсон.

⁶² Статистикийн мэдээллийн сан дахь мэдээллээр 2020 оны эцэст 220 өмгөөллийн нөхөрлөл бүртгэгдсэн байна. Эх сурвалж:

https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2300_037V7&CR008_select_all=0&CR008SingleSelect=_5&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table Сүүлд нэвтэрсэн.2021.09.25

хөгжлийн бэрхшээлийн тухай, хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээг харгалзан түгээмэл загвар, боломжит тохируулгаар хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна.			
11.3.Монгол дохионы хэл бол сонсголтгүй хүний эх хэл бөгөөд өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь сонсголтгүй хүний дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхийг хангана.	66,118,290	129,390,000	195,508,290
12.1.Брайль бичгийг ашиглан боловсрол эзэмших нөхцөлийг бүх шатны боловсрол, сургалтын байгууллага, мэдээлэл авах, нийгмийн харилцаанд	516,266,100	34,504,000	550,770,100
23.4.Шүүх, прокурор, өмгөөлөл хууль хяналтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах ба үйлчилгээний зардлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон шүүхийн, прокурорын тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэнэ.	18,573,500	6,600,000	25,173,500
40.1.8.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчих, ялгаварлах, бэлгийн дарамт үзүүлэхийг үл тэвчих асуудлыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх;	165,249	Зардал үүсэхгүй	165,249
Нийт	3,082,855,049	866,046,200	3,948,901,249

Дээрх нэгтгэлээс харахад хуулийн төсөлд тусгасан үүрэг хүлээсэн 25-аас дээш ажилтантай хуулийн этгээд, хувийн хэвшлийн маргэжлийн болон дээд боловсролын байгууллагууд, өмгөөллийн нөхөрлөлүүд болох 4630 хуулийн этгээдэд нийт **3,941,703,849** төгрөгийн зардал үүснэ гэж үзлээ.

ГУРАВ. ХУВЬ ХҮНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

5.5.Хувийн туслах үйлчилгээний зардлын нэг цагийн үнийн дүнгийн 10 хувийг үйлчлүүлэгч хувь хүн өөрөө төлнө. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389877818731&showType=1>

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хөгжлийн бэлхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зардлын тооцоо хийхийн гол зорилго нь хуулийн төслийн хүрээнд төрийн захиргааны байгууллагад болон хуулийн этгээдэд шинээр бий болж байгаа үүргээс үүдэлтэй ачааллыг хөнгөвчлөхөд оршино. Иймд эрх зүйн тухайн зохицуулалт буюу бэлтгэж буй төсөлд төрд болон хуулийн этгээдэд үүсэх зардлыг хэмнэх боломж бий эсэхийг гэдгийг шалгах боломж үүснэ.

Төрд буюу төрийн захиргааны болон төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагад үүсэх зардлын тухайд:

Уг хуулийн төсөлд шинээр нэмэгдсэн зохицуулалтуудаар төрд хүлээлгэсэн үүрэг буюу хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад Засгийн газарт 0,3 хүн, ХБХ-ий асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд 0,42, Боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд 0,18, ХЗДХ-ийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүнд 0,06, ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад 10,81, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад 0,14, төрийн өмчийн сургалтын байгууллагад 0,004, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт 40,9, улсын төсвийн болон ТӨҮГ-т 0,02 хүний нөөцийг шинээр бий болгох шаардлагатай байна.

Аливаа үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ 1 бүхлээс доош байгаа тохиолдолд тухайн үүргийг дотоод зохион байгуулалт, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар хүний нөөцийн ачаалал шинээр үүсгэхгүйгээр зохицуулах боломжтой гэж үздэг.

Иймээс зөвхөн хүний нөөцийн хэрэгцээ нь 10,8 хүн гэж гарсан ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудад үүсэх хүний нөөцийн зардал болон хүний нөөцийн хэрэгцээ нь 40,9 хүн гэж гарсан Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт байгууллагад үүсэх хүний нөөцийн зардлыг тооцож үзэхэд цалингийн зардал 1,135,928,665 төгрөг, материаллаг зардал 26,127, 816 төгрөг, бусад зардал 42,676,366,696 төгрөг байгаа нь төрд үүсэх нийт зардлын хэмжээ **44,201,902,908 төгрөг болох тооцоолол гарсан.**

Хуулийн этгээдэд үүсэх зардлын тухайд

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн этгээдэд зардал үүсгэх зохицуулалт агуулсан 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3, 12 дугаар зүйлийн 12.1, 23 дугаар зүйлийн 23.4, 40 дүгээр зүйлийн 40.1.8 дахь хэсэг, заалтуудын хүрээнд зардлын тооцоо хийсэн.

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцохдоо 25-аас дээш ажилтантай хуулийн этгээд, хувийн хэвшлийн маргэжлийн болон их, дээд боловсролын байгууллагууд, өмгөөллийн

нөхөрлөлүүд болох 4630 хуулийн этгээдэдийн тоог жишиг болгон ашигласан бөгөөд тэдгээр хуулийн этгээдэд **3,941,703,849** төгрөгийн үйл ажиллагааны болон нэмэлт зардал үүсэх төлөвтэй байна.

Төрд болон хуулийн этгээдэд үүсэх нийт зардлын тухайд

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрд болон хуулийн этгээдэд зардал үүсгэх зохицуулалтуудын үр дүнд нийт **47,273,071,766** төгрөгийн зардал үүсэх урьдчилсан тооцоо гарлаа.

Зардлын тооцооны үр дүнд үндэслэн хууль санаачлагчид дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Төр буюу төрийн байгууллагад үүсэх ачааллыг бууруулах чиглэлээр:

1. Алслагдсан аймаг, сумдад байнга оршин суудаг ХБХ болон бүрэн хараагүй хүний нийслэлд ирж эмчилгээ хийлгэх, шинжилгээ өгөх болон буцах замын зардлыг нөхөн олгохтой холбоотой гарах замын зардлыг олгох асуудлын хүрээнд “дээрх эмчилгээ, шинжилгээнд хамрагдах зайлшгүй шаардлагатай хүн”-ий тоог нарийвчлан гаргаснаар зардлын хэмжээг бууруулах боломжтой. Үүнээс гадна бүсийн эмчилгээ, оношлогооны төвүүдийн хүчин чадал, тоног төхөөрөмжийг шинэчлэх, эмч, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх замаар ХБХ өөрт ойр эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэснээр улсын төсвөөс жил бүр гарах зардлыг хэмнэх, ХБХ-ээс гадна алслагдсан орон нутгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар дээшлэх давхар ач холбогдолтой байна.
2. ХБХ-ий эрхийг хамгаалах салбарын ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, нөхөх олговор, шагнал урамшуулал авах, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг хамгаалах, өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж, цол авах, хөнгөлөлт, урамшуулалд хамрагдах, орон сууц барих эсхүл худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл, тусламжид хамрагдах зэрэг эрхийг шинээр тусгаж өгсөн. Гэвч “ХБХ-ий эрхийг хамгаалах салбарын ажилтан” гэж аль салбарын, ямар мэргэжлийн, ямар тусламж, үйлчилгээ эрхэлж буй ажилтан, албан хаагчийг ойлгох нь тодорхойгүй байгаа тул энэ хуулиар нийгмийн баталгааг нь хангах шаардлагатай салбар, байгууллага, ажил мэргэжил зэргийг тодорхойлох шаардлагатай гэж үзлээ.
3. ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр улсын байцаагч ажиллуулахтай холбоотой зохицуулалтыг үнэлэх боломжгүй байна. Тухайлбал, улсын байцаагч хаана харьяалагдах, мэргэжлийн хяналтын байгууллагын чиглэл чиглэл хариуцсан улсын байцаагчдын чиг үүрэгтэй давхцахгүй ямар төрлийн хяналт тавих, хэдэн улсын байцаагчтай байх зэрэг асуудлыг тодруулах, чиг үүргийн давхардал үүсгэхгүй байхад анхаарах шаардлагатай
4. ХБХ-ий бүртгэл, мэдээлэл, судалгааг оршин суугаа байршил, өвчний төрөл, зэрэглэл зэрэг олон талт байдлаар нарийвчлан хөтлөх нь цаашид ХБХ-ий хэрэгцээ шаардлагад нийцсэн, тэдний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн аливаа төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа гаргах зэрэг үйл ажиллагааг бодитой, хүртээмжтэй төлөвлөхөд сайн нөлөө үзүүлэхээр байгааг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Хуулийн этгээдэд үүсгэх ачааллыг бууруулах чиглэлээр:

5. Бүх шатны боловсролын байгууллага ХБХ-ийг хувийн туслахаар хангах тухай эрх зүйн зохицуулалт нь нэг талдаа ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангахад чухал нөлөө үзүүлэхүйц зохицуулалт болсон боловч нөгөө талдаа сургалтын байгууллагад санхүүгийн дарамт учруулж байгаа тул тухайн боловсролын байгууллагын хандлагаас хамааран ХБХ-ийг сургахгүй байх сөрөг нөлөө үзүүлж болохоор байна. Иймээс сургалтын байгууллагад хувийн туслахаар хангах асуудлаар ямар дэмжлэг үзүүлэх, ямар ХБХ-д хувийн туслах зайлшгүй шаардлагатай гэж үзэх зэрэг асуудлыг илүү тодотгож өгснөөр энэ зохицуулалтын хүрээнд үүрэг хүлээх байгууллагаас гарах зардлыг багасгах боломжтой юм.
6. Дохионы хэлмэрчийн тусламжтайгаар нийгмийн харилцаанд оролцуулах зохицуулалтын хүрээнд хуулийн этгээдэд үүсэх зардлыг багасгах тухайд дохионы хэлмэрч зайлшгүй биечлэн байх шаардлагатайгаас бусад тохиолдолд цахимаар буюу зайнаас оролцох нөхцөлийг бүрдүүлэх нь хуулийн этгээдэд үүсэх зардлыг бууруулахад нөлөөлнө. Манай улс энэ төрлийн үйлчилгээг төрийн зарим үйлчилгээг авахад нэвтрүүлж эхэлсэн байгаа тул түүнийг улам илүү хөгжүүлэх, төрийн байгууллагаас гадна хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд ашиглах боломжтой байхаар шинэчлэх нь урт хугацаандаа дохионы хэлмэрчээр дамжуулан нийгмийн харилцаанд оролцох иргэдийн эрх ашгийг нийгмийн бүхий л салбарт хангахад үр дүнтэй шийдэл байхаар байна.
7. Браиль бичиг ашиглан боловсрол эзэмших, мэдээлэл авах, нийгмийн харилцаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтын хүрээнд үүрэг хүлээх хуулийн этгээдэд үүсэх зардлыг бууруулахын тулд харааргүй иргэд зайлшгүй үйлчлүүлэх үйл ажиллагааны тодорхой салбар, чиглэлүүдийг тодорхойлох, тэдгээр салбар, чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдэд мэдээллээ брайль бичгээр байршуулах үүргийг үлдээж, бусад салбар, чиглэлийн тухайд “хувийн туслах”-ын үйлчилгээ авах боломжтийг нээлттэй үлдээх нь энэ зохицуулалтын хүрээнд үүрэг хүлээх хуулийн этгээдийн тоог багасгах, улмаар гарах зардлыг бууруулах боломжтой юм.
8. Өмгөөллийн нөхөрлөлүүдэд ХБХ-нд хүртээмжтэй орчныг бий болгохоос гадна, текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрчээр үнэ төлбөргүй хангах үүрэг хүлээлгэсэн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй байна. Учир нь цөөн тооны томоохон өмгөөллийн нөхөрлөлөөс бусад нь ажлын байраа түрээслэдэг тул хуульд заасан хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд ихээхэн зардал, хүндрэл үүсгэхээр байна. Энэ тохиолдолд ч мөн адил байгууллагын удирдлага, ажилтны хандлагаас хамааран ХБХ-ийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч зэргээр үнэ төлбөргүй хангаж үйлчилгээ үзүүлэх асуудлын эерэг, сөрөг үр дагавар илрэнэ. Тиймээс одоо хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлж буй тогтолцоог ХБХ-д ээлтэй болгох замаар, тухайлбал, Монголын Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн туслалцааны төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын хууль зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй үзүүлж буй нэгжүүдэд ХБХ-ий хууль зүйн туслалцаа авах нөхцөлийг бүрдүүлсэн тоног төхөөрөмж, брайль бичгийн ном, эмхтгэл, мэдээллийг байршуулах, хэлмэрч, орчуулагч /гэрээгээр/ ажиллуулах зэргээр ХБХ-нд хаана хандах, ямар үйлчилгээ авах нь ойлгомжтой, тодорхой байдлыг бий болгох замаар нэгд, өмгөөллийн нөхөрлөлүүдэд үүсэх зардлыг хэмнэх, хоёрт, ХБХ илүү чанартай, бүрэн дүүрэн мэдээлэл авах орчин бүрдэх магадлалтай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, бүс, аймаг, нийслэл, хүйс, улирал, жилээр. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www.1212.mn/>
2. Ерөнхий боловсролын сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид, бүс, аймаг, нийслэлээр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www.1212.mn/>
3. Зам тээврийн сайдын 2013 оны “Автотээврийн жишиг тариф шинэчлэн батлах тухай” 162 дугаар тушаал. Эх сурвалж: <https://mrt.d.gov.mn/upload/files/91da3ee7284330ef998ff3d8e3f4049d.pdf>
4. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 190 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн чиглэл” Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/8011?lawid=12861>
5. Засгийн газраас зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөтөлбөрийн хүрээнд баригдсан “буянт-ухаа 1” хорооллын орон сууцанд иргэдээс захиалга авах журам ЗГ-ын 2014 оны 36-р тогтоол. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/6240?lawid=9810>
6. Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт: Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ. Эх сурвалж: <https://www.ac.mn/c/950432?content=965345>
7. ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох журам, үндсэн хөрөнгийн дэдэгдэл, хорогдлыг тооцоход баримтлах хугацаа”
8. ЗГ-ын 2016 оны 136 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам. 4.1.
9. ЗГ-ын 2017 оны 197 тогтоолын 5р хавсралт Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам: Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/7964?lawid=12824>
10. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/10380?lawid=14892>
11. Улаанбаатар хотын орон сууцны нөхцөл байдлын тойм судалгаа (2010-2018). <http://mirim.mn/>
12. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо, улирал, хариуцлагын хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www.1212.mn/>
13. ХНХЯ-наас ирүүлсэн мэдээлэл. 2021.09.21
14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа. 2020 он. Эх сурвалж: https://mlsp.gov.mn/uploads/files/hbi_nom2020.pdf
15. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын тайлан. Д.Сүнжид. 2018 он
16. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
17. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
18. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмын Нэгдүгээр хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие

даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зардлын хэмжээг тодорхойлох аргачлал”

19. Хууль тогтоомжийн тухай хууль аргачлал, гарын авлага. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах” төсөл. Улаанбаатар хот. 2016 он.
20. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн 2014 он. эх сурвалж: <http://www.audit.gov.mn/files/report/compliance/tailan-emds.pdf>